



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 ОНЫ III УЛИРАЛ



Цахим хувилбар

Энэхүү тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт нь Эдийн засаг, хөгжлийн яамны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Уг тайланг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд “Макро эдийн засгийн танилцуулга, 2025 оны 2 дугаар улирал, Эдийн засаг, хөгжлийн яам” гэж эх сурвалж хэсэгт тодотгоно уу.

Санал, хүсэлт ирүүлэх, бусад мэдээллийн талаар тодруулах бол MEPD@med.gov.mn цахим шуудан эсвэл дараах хаягаар хандана уу.

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, Улаанбаатар хот 15141, Монгол Улс

ЭКСПОРТЫН СЭРГЭЛТ
2025 оны III улирал

Агуулга

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ.....	7
БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ.....	9
1. БОДИТ СЕКТОР.....	11
1.1. Нийлүүлэлт.....	12
1.2. Эрэлт.....	22
1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж.....	24
1.4. Эдийн засгийн мөчлөг.....	30
2. ТӨСВИЙН СЕКТОР.....	17
2.1. Төсвийн гүйцэтгэл.....	18
2.2. Төсвийн төлөв.....	18
2.3.Засгийн газрын өрийн тогтвортой байдал.....	19
3. МӨНГӨНИЙ СЕКТОР.....	23
3.1. Инфляц.....	24
3.2. Мөнгө ба санхүүгийн салбар.....	28
4. ГАДААД СЕКТОР.....	33
4.1. Гадаад худалдаа.....	34
4.2. Төлбөрийн тэнцэл, гадаад өр.....	38
5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ.....	38
5.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал.....	44
5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага.....	45
5.3. Олон улсад зарлагдсан индексүүд.....	47
Макро эдийн засгийн тойм.....	Error! Bookmark not defined.
Хавсралт.....	53

Зураг, хүснэгт, шигтгээний жагсаалт

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт (нийлүүлэлт талаас).....	17
Зураг 1.2. Бодит ДНБ-ий өсөлт (эрэлт талаас).....	23
Зураг 1.3. Хөдөлмөрийн зах зээл.....	24
Зураг 1.4. Аж ахуйн нэгж.....	27
Зураг 1.5. Хэрэглэгчийн итгэлийн индекс, улирлаар.....	28
Зураг 1.6. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт.....	29
Зураг 1.7. Үйлдвэрлэлийн зөрүү.....	30
Зураг 2.1. Төсвийн орлого.....	19
Зураг 2.2. Төсвийн зарлага.....	19
Зураг 2.3. Төсвийн тэнцэл ба төлөв.....	18
Зураг 2.4. Засгийн газрын өр.....	19
Зураг 2.5. Засгийн газрын өрийн тогтвортой байдал.....	20
Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн.....	24
Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс.....	25
Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ.....	27
Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд.....	28
Зураг 3.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд.....	29
Зураг 4.1. Экспорт.....	34
Зураг 4.2. Импорт.....	36
Зураг 4.3. Экспортын голлох үзүүлэлтүүд.....	37
Зураг 5.1. Дэлхийн тодорхой бус байдлын индекс.....	44
Зураг 5.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ.....	45
Зураг 4.3. Урсгал болон санхүүгийн дансны тэнцэл, төгрөгийн хани.....	Error! Bookmark not defined.
Зураг 4.4. Урсгал данс, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өр.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 1.1 Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор.....	26
Хүснэгт 1.2. Хэрэглэгчийн итгэлийн индексийн бүрэлдэхүүн.....	28
Хүснэгт 3.1. Санхүүгийн салбарын эмзэг байдал.....	31
Хүснэгт 4.1. Гадаад өрийн тогтвортой байдал.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 5.1. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн Монгол Улсын оноо, эрэмбэ.....	47
Шигтгээ 1. Тогтвортой дэд бүтцийн талаар.....	18
Шигтгээ 1. Хэрэглэгчийн итгэлийн индекс.....	28
Шигтгээ 2. Хөдөлмөрийн зах зээлийн цахим хуудаснууд дахь ажлын байрны зарын тоо оны сүүлийн хагаст буурсан байна.....	29
Шигтгээ 3. Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 51 дугаар тогтоол.....	37
Шигтгээ 5. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл.....	49

Товчилсон үг

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж, ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УЦС	Усан цахилгаан станц
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Эдийн засгийн өсөлтийн хурд өмнөх оны мөн үеийн орчимд хадгалагдлаа. ДНБ нэрлэсэн дүнгээр 60.1 их наяд төгрөгт хүрч 8.5 хувиар, бодит дүнгээр 24.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар өсөв. Хөдөө аж ахуй, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн өсөлт улирал дамнан хадгалагдаж, уул уурхайн салбар сэргэсэн нь эдийн засгийн өсөлтийг тэтгэсэн бол тээвэр, худалдааны салбар эдийн засгийн өсөлтийн эрчмийг сулрууллаа.

Уул уурхайн салбар өмнөх улирлуудаас огцом өсөж III дугаар улиралд 8.2 хувьд хүрснээр эдийн засгийн өсөлтийн 1.1 хувийг бүрдүүлээ. Өсөлтийг зэс, төмөр, жонш, цайрын баяжмал үйлдвэрлэл голлон дэмжсэн бол алт, нүүрс, газрын тосны үйлдвэрлэл хязгаарлалаа. Хаваржилт тогтуун байж, мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний дүнд оны эхний гурван улиралд мал аж ахуйн үйл ажиллагаа сэргэн, хөдөө аж ахуйн салбар 33.8 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 3.4 нэгж хувиар дэмжив. Мөн Улаанбаатар хотын орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын голлох нөлөөгөөр барилгын салбар оны эхний гурван улиралд 22.2 хувиар өслөө. Түүнчлэн барилга угсралт, их засварын ажлын өсөлтийг дагасан төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн өсөлтийг дагасан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэнээр боловсруулах салбар сэргэж, эдийн засгийн өсөлтийг дэмжив.

Харин тээврийн салбар, тэр дундаа авто замаар тээвэрлэх нүүрс тээврийн орлого буурсны голлох нөлөө үргэлжилсээр тээврийн салбар 6.1 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг хязгаарлалаа. Экспортын нүүрс тээврийн зай багассан нь авто тээврийн салбарын шатахуун зарцуулалтыг бууруулсан, мөн автомашины импортын худалдаа багассан зэргээс үүдэн бөөний болон жижиглэн худалдааны салбарын шатахууны борлуулалт буурснаар гуравдугаар улиралд 5.1 хувиар агшлаа.

Эрэлт талаас эдийн засгийн өсөлтийг хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээний тэлэлт дэмжсэн бол экспортын бууралт өсөлтийг саарууллаа. Ажиллагчид нэмэгдэж, ажилгүй иргэдийн тоо буурснаар хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өсөж, 59.1 хувьд хүрч нэмэгдсэнээр өрхийн нэрлэсэн орлого өсөхөд нөлөөлж, өрхийн хэрэглээг дэмжив. Харин үнийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн бодит орлогын өсөлт удааширлаа. Хөрөнгийн хуримтлалын өсөлтөд малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс буурч биологийн өсөж үрждэг хөрөнгийн нөөц 1.1 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Мөн орон сууц болон бусад барилга байгууламжийн нөөц өссөн нь хөрөнгийн хуримтлалыг дэмжлээ. Бараа, үйлчилгээний импорт сүүлийн 2 жил тасралтгүй 20 гаруй хувиар бодитоор нэмэгдэж байсан нь 1.5 хувь болж буурсан, мөн бараа, үйлчилгээний экспорт 4.5 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтийг саарууллаа.

Импортын өсөлт саарсан ч экспорт буурснаар урсгал дансны алдагдал тэллээ. Импорт 2025 оны эхний 3 улиралд өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар буурсан бөгөөд тэр дундаа эдийн засаг, үйлдвэрлэлийг дэмждэг аж үйлдвэрийн орцын болон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдийн импорт буурсан байна. Харин экспортын орлого өмнөх оны мөн үеэс 16 хувь буураад байна. БНХАУ-ын коксжих нүүрсний олборлолт нэмэгдсэнээс гадна гангийн томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний эрэлт буурсан нь манай улсын нүүрсний экспортын хэмжээнд сөргөөр нөлөөллөө. Мөн гадаад орчны тодорхойгүй байдал нэмэгдэж, дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ буурснаар экспортын орлого бууралтад голлох нөлөөг үзүүлэв. Бараа, үйлчилгээний импорт агшиж, цалингийн төлбөр, хөрөнгийн өгөөж, ногдол ашиг зэрэг анхдагч орлогын дансны алдагдал өмнөх оны мөн үеэс буурсан ч барааны экспорт буурснаар урсгал дансны алдагдал 1.7 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 450 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

Төсвийн орлого төвлөрүүлэлт нүүрсний үнэ болон экспортын орлого буурсны улмаас саарлаа. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого нүүрсний үнийн бууралттай холбоотой уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлого саарч, 2025 оны 3 дугаар улиралд 20.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.7 их наяд төгрөг буюу 3.1 хувиар буурсан байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 21.9 их наяд төгрөг төвлөрөхөөр төлөвлөсөн хэдий ч тус төлөвлөгөөнөөс 1.2 их наяд төгрөг буюу 5.6 хувиар доогуур гүйцэтгэлтэй гарсан байна. Улмаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.3 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Нөгөө талаас төсвийн нийт зарлага 22.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар тэлэхэд урсгал зарлагын өсөлт, тэр дундаа төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Инфляц 2025 оны 3 дугаар улирлын эцэст 9.0 хувь болж эрчимжлээ. Инфляц сүүлийн улирал эрчимжихэд хүнсний үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Эрэлтийн шалтгаантай инфляц алгуур саарах хандлагатай байсан ч нийлүүлэлтийн гаралтай инфляц мах, хүнсний ногоо зэрэг хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан өсөв. Харин хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц алгуур буурах хандлагатай байна. Төв банкнаас мөнгөний бодлогын хүүг 2025 оны 3 дугаар улирлын туршид 12 хувьд хадгалав.

Зээлийн өсөлт алгуур саарч байна. Арилжааны банкнуудын зээлийн жилийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 22.1 хувьд хүрч үргэлжлэн саарсан байна. Шинээр олгосон зээлийн хувьд бизнесийн зээл давамгайлж байгаа бол хэрэглээний зээлийн өсөлт буурсан байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өмнөх улирлаас эрчимжиж 5.6 хувьд хүрлээ. Тодруулбал, дотоодын зээл мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон бүрдүүлэв. Түүнчлэн, банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 12 хувиар өссөн байна. Нийт хадгаламжийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 14.7 хувьд хүрсний дийлэнх хэсгийг иргэдийн төгрөгийн хадгаламж бүрдүүллээ.

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Дэлхийн тодорхой бус байдал цаашид ч нэмэгдэх эрсдэлтэй байна. Дэлхийн тодорхой бус байдлын индекс түүхэн дээд түвшинд хүрээд байгаа бөгөөд худалдааны дайны цар хүрээ улам бүр тэлж болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт, ОХУ-Украины дайн болон Ойрх Дорнодын тогтворгүй байдал зэрэг эдийн засаг, геополитикийн тогтворгүй байдлын эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг сулруулж болзошгүй байна.

Зэс, алтны үнийн өсөлт хадгалагдах төлөвтэй байгаа бол нүүрс, төмрийн хүдрийн үнэ сэргэх хандлага бага байна. Дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал нэмэгдэж, төв банкнуудын алт худалдан авалт өссөн нь аюулгүй хөрөнгийн эрэлтэд түлхэц болж, алтны үнийг өсөхөд хүргэлээ. Мөн цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүч, тоон өгөгдөл боловсруулах төвүүд, технологийн салбарын хурдацтай хөгжлөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байгаа бөгөөд 2025 онд зэсийн дундаж үнэ 9,200 ам.долларт хүрэх төлөвтэй байна. Харин худалдааны дайн болон БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтаас шалтгаалан нүүрсний үнэ 2025 оны эхний хагас жилийн байдлаар 66 ам.доллар болж, 41 хувиар буураад байна. Олон улсын шинжээчид нүүрсний үнэ богино хугацаанд огцом сэргэхгүй гэж үзсэн тул 2025 онд нүүрсний дундаж үнэ 70 орчим ам.долларт хадгалагдах төлөвтэй байна.

Эдийн засгийн өсөлт 2025 онд 6.5 орчим хувь байхаар тооцоолж байна. Салбаруудаар авч

үзвэл, хөдөө аж ахуй, боловсруулах салбарын үйлдвэрлэл сэргэж, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төлөвтэй байна. Тухайлбал, Оюу толгойн баяжмал дахь зэс, алтны агуулга өссөнөөр дэлхийн зах зээл дээр эрэлттэй энэ үед өсөлтийг голлон дэмжихээр байна. Эрэлт талаас хөрөнгө оруулалт болон өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг үргэлжлүүлэн дэмжих хүлээлттэй байна. Мөн мал аж ахуйн салбарт эх малын тоо, төл бойжилт нэмэгдэх нөлөөгөөр нийт хөрөнгийн хуримтлал өсөж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд саарах хандлагатай байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн нөлөөгөөр 2025 онд ажиллагчдын тоо нэмэгдэхээр хүлээгдэж байна. Энэхүү өсөлтөд нийт ажиллагчдын 4 хүн тутмын нэг нь ажиллаж буй хөдөө аж ахуйн салбарын сэргэлтээс шалтгаалан тус салбарын ажиллагчдын тоо нэмэгдэх нь голлон нөлөөлж, нийт ажил эрхлэлтийн өсөлтийг дэмжихээр байна.

Инфляц 2025 оны эцэст төв банкны зорилтын дээд интервал орчимд байх төлөвтэй байна. Цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний үнэ өсөх хандлагатай байсны зэрэгцээ эрэлтийн гаралтай инфляц болон хүнсний инфляц өндөр байсан бол 2025 оны сүүлээс саарч, тогтворжихоор байна. Гэсэн хэдий ч цаашид геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тэвэр логистикийн саатлаас үүдэн инфляц өдөөгдөх эрсдэлүүд хадгалагдаж байна.

Бүлэг 1

БОДИТ СЕКТОР

- 1.1. Нийлүүлэлт
- 1.2. Эрэлт
- 1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж
- 1.4. Эдийн засгийн мөчлөг

1. БОДИТ СЕКТОР

ТОЙМ

Эдийн засаг оны эхний гурван улиралд 5.9 хувиар өслөө. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн хэвээр байгаа бол уул уурхай, барилга, боловсруулах салбаруудын үйл ажиллагааны идэвхжил нэмэгдэн өсөлтийг мөн дэмжиж байна. Харин тээвэр болон худалдааны салбар агшилттай байна. Эрэлт талаас хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол барааны экспорт буурсан нь өсөлтийг саарууллаа. Ажиллах хүчний оролцооны түвшин 62.7 хувьд хүрч, өрхийн бодит орлого 8 хувиар өссөн нь өрхийн хэрэглээг дэмжлээ. Эдийн засгийн потенциал өсөлтийн эрчим нэмэгдэж, 5-6 хувьд хүрсэн ба нийт үйлдвэрлэлийн түвшин потенциал үйлдвэрлэлийн орчимд байна.

1.1. Нийлүүлэлт

1. Эдийн засгийн өсөлт 5.9 хувьд хүрлээ. ДНБ 2025 оны эхний гурван улиралд нэрлэсэн дүнгээр 60 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар, бодит дүнгээр 24.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеийн орчимд байж, төсөөлөлтэй нийцтэй байна. Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол тээвэр, худалдааны салбарууд агшиж, өсөлтийг сааруулав. Эдийн засгийн өсөлтийг 2025 онд 5.5 хувь байхаар төсөөлж байсныг 6.5 хувь болохоор шинэчлэн боловсрууллаа.

2. Уул уурхайн салбарын өсөлт 8.2 хувьд хүрч сэргэн, нийт эдийн засгийн өсөлтийн 1.1 хувийг бүрдүүлэв. Уул уурхайн салбар III улиралд сэргэснээр эдийн засгийн өсөлт оны эхний хагас жилийн 1.1 хувиас огцом нэмэгдлээ. Зэсийн баяжмал үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 37 хувиар, тухайлбал Оюу толгой гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр оны эхний гурван улиралд 53.7 хувиар өссөн нь уул уурхайн салбарын өсөлтийг голлон дэмжив. Мөн төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн өсөлт хадгалагдан 6.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 41.5 хувиар өслөө. Харин нүүрс олборлолт 2025 оны эхний гурван улиралд 68.9 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар буурав. Мөн газрын тос олборлолт 7 улирал дараалан буурч, 2.8 сая тонн болсон бол алтны олборлолт 11 улирал дараалан буурч, 8.7 тонн болсноор уул уурхайн өсөлтийг сааруулав.

Уул уурхайн салбартай холбоотойгоор Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 55 дугаар тогтоолоор “Ашигт малтмал экспортлогч аж ахуйн нэгж нь тухайн төрлийн экспортын бүтээгдэхүүний дөрөвний нэг, түүнээс дээш хувийг Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан тохиолдолд нийт экспортод гаргасан тухайн төрлийн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын

үнэлгээг уурхайн бүтээгдэхүүний бирж (Монголын хөрөнгийн бирж)-ийн арилжааны үнээр тооцож, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахаар баталсан. Тус шийдвэрийг 2025 он дуустал хүчинтэй байхаар баталсан бөгөөд богино хугацаанд уул уурхайн салбарын орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байв.

3. Уул уурхайн бус салбар 5.6 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийг 4.9 нэгж хувийг бүрдүүлэв. Хөдөө аж ахуйн салбарын өсөлт хадгалагдаж, барилга, боловсруулах, эрчим хүчний салбарын өсөлт эрчимжлээ. Үйлчилгээний салбаруудын өсөлтийн эрчим алгуур саарч байгаа бол тээвэр, худалдааны салбар агшилттай хэвээр байна.

4. Хөдөө аж ахуйн салбарын өсөлт төсөөллийн орчимд байна. Бойжсон төлийн тоо толгой 21.1 саяд хүрч (төл бойжилт 98.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.6 сая толгой малаар нэмэгдэж, том малын зүй бус хорогдол 199 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.9 сая толгой малаар буурснаар хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн эрчим өмнөх улирлын орчимд хадгалагдлаа. Харин газар тариалангийн салбарын хувьд оны эхний хагаст тариалангийн гол бүс нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас унаснаар нийт хураасан үр тариа өмнөх оноос 149.7 мянган тонн, төмс 133.6 мянган тонн, хүнсний ногоо 15.2 мянган тонноор таримал тэжээл 22.4 мянгаар тус тус буурснаар хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн хурд өмнөх улирлаас удааширч, 2025 оны эхний 3 улирлын байдлаар хөдөө аж ахуйн салбар 33.8 хувиар өсөж, нийт өсөлтийн 3.4 нэгж хувийг бүрдүүллээ.

Хөдөө аж ахуйн салбарт төрөөс дараах томоохон шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд,

- Газар тариалан, мал аж ахуйн төгс хослолыг бий болгож, хүнс, хөдөө аж ахуйг эдийн засгийн тулгуур салбар болгон хөгжүүлэх зорилтын

хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-г 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай өрнүүлэхээр шийдвэрлэв. Үүнтэй уялдуулан Засгийн газрын 2025 оны 166 дугаар тогтоолоор нийт 71.2 мянган га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэв. Үүнд,

- Дархан-Уул аймгийн Орхон суманд 1137.80 га, Хонгор суманд 2937.07 га болон 895 га,
- Дундговь аймгийн Сайхан-Овоо суманд 524 га,
- Дорнод аймгийн Баяндун суманд 497.1 га, Матад суманд 15000 га, Булган суманд 1500 га, Баянтүмэн суманд 3000 га, Халх гол суманд 30000 га, Чулуунхороот суманд 4000 га,
- Төв аймгийн Мөнгөнморьт суманд 651.16 га, Баяндэлгэр суманд 957.84 га,
- Хэнтий аймгийн Баян-Адарга суманд 72.8 га, Баян-Овоо суманд 431 га, Биндэр суманд 577.4 га, Баянхутаг суманд 1049 га,
- Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 600 га, 4655.16 га болон 2749.69 га байна.

Атар-4 аян хэрэгжсэнээр усалгаатай газар тариалан нэмэгдэж, өвлийн хүлэмж, агуулахын хүчин чадал тэлж, эрчимжсэн мал ахуйг дэмжих тэжээлийн үйлдвэрлэлийн бааз суурь бүрдэх зэргээр хөдөө аж ахуйн салбарыг эрчимжсэн, бүтээмжит хэлбэрт шилжүүлэх үндэс бүрэлдэнэ гэж хүлээж байна. Тус аян нь хөдөө аж ахуйн салбарын дунд хугацааны тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй юм.

Засгийн газрын 2022 оны “Техникийн зохицуулалт батлах тухай” 380 дугаар тогтоолоор ямааны угаасан ноолуурын экспортыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хориглохоор шийдвэрлэсэн. Том малын зүй бус хорогдлын хэмжээ 2023 онд 4.9 сая толгойд хүрч, малчдын орлого буурах эрсдэл үүссэн тул угаасан ноолуурын экспорт хориглох асуудлыг 2025 оны 7 дугаар сар хүртэл түдгэлзүүлэх шийдвэрийг

2023 оны 2 дугаар сард гаргаснаар, ноолуурын үнэ 2023 оны хавар 119,200 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 11.2 мянган төгрөгөөр өсөж малчдын орлого хамгаалагдсан. Харин Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” тогтоолоор баталсан “Цагаан Алт” хөдөлгөөнийг үр дүнтэй зохион байгуулах үйл ажиллагааг дэмжих чиглэлд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоолоор тус 380 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, угаасан ноолуурын экспортыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хориглохоор шийдвэрлэв. Монгол Улсын 2025 оны түүхий ноолуурын гарц 8 мянган тонн орчим байгаагаас угаасан ноолуурын экспортыг хориглосонтой холбоотойгоор малчдын орлогыг бууруулахгүй байх, самнах үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийг жигд хангах зорилтын хүрээнд 2025 онд 5,600 тонн түүхий ноолуур бэлтгэх шаардлагыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тодорхойлсон. “Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын байдлаар 230 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг ноолуур бэлтгэлийн үйл ажиллагаа эрхлэгч 30 аж ахуйн нэгж авч нийт 1,525 тонн ноолуур бэлтгэсэн. Харин бэлтгэх шаардлагатай үлдэгдэл 4,075 тонн ноолуурыг зах зээлийн эргэлтэд оруулахад Засгийн газраас санхүүжилтийн нэмэлт бүтээгдэхүүн болох вексель гаргах тэмдэглэлийг гаргаж, төрөөс санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд 2025 онд 4,020 тонн ноолуур самнаж, түүхэн дээд түвшинд хүрлээ. Нэг талаас угаасан ноолуурын экспортыг хориглох замаар самнасан ноолуур үйлдвэрлэлийг дэмжих нь нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүнийг дэмжих нөлөөтэй боловч нөгөө талаас самнах үйлдвэрүүд төрийн санхүүгийн дэмжлэгээс хараат байгаа нь малчдын орлого буурах эрсдэлийг дагуулж байна. Иймд ноолуурын зах зээлд дунд хугацаанд тул төрийн санхүүгийн дэмжлэгийн дуусгавар болох хугацааг тодорхойлон, өрсөлдөөний орчныг дэмжих замаар зах

зээлийн чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байна.

5. Аж үйлдвэрийн салбарын¹ өсөлт эрчимжлээ. Боловсруулах салбарын өсөлт эрчимжиж, 2025 оны эхний 3 улирлын байдлаар 7.7 хувиар өслөө. Үүнд, химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл², төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл³ боловсруулах салбарын өсөлтийг голлон дэмжсэн хэвээр байна.

Эрчим хүчний салбарын өсөлт тогтвортой хадгалагдаж байна. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбар 2025 оны эхний гурван улиралд 8.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг 0.2 хувиар дэмжлээ. Үүнд шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-уудын үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөлөв. Тухайлбал, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 6.2 тэрбум кВт цагт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 10.8 сая.Гкалд хүрч, 7.2 хувиар нэмэгдэн эрчим хүчний салбар үйлдвэрлэлийн өсөлт тогтвортой хадгалагдлаа.

Барилгын салбарын өсөлтийг Улаанбаатар хот дахь эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшгийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд, Сэлэнгэ аймаг дахь 70МВт хүчин чадал бүхий дулааны цахилгаан станц, Дорнод аймгийн авто замын бүтээн байгуулалтын ажлууд үргэлжлүүлэн тэтгэснээр 2025 оны эхний 3 улирлын байдлаар 22.2 хувиар өслөө.

Барилга, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлд төрөөс дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд,

- Засгийн газрын 2025 оны 27 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын

урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан тэргүүн ээлжид хэрэгжүүлэх 14 мега төсөл болон тогтвортой хөгжлийг хурдасгах 149 төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Тусгай үүрэгт элчин томилох тогтоолыг гаргасан.

- Түүнчлэн Засгийн газрын 2025 оны 28 дугаар тогтоолоор Оюу толгой төслийн хөрөнгө оруулагчтай үүссэн татварын маргаан болон "Антре Гоулд" ХХК-ийн эзэмшиж байгаа талбайн хилийн заагийг тогтоох асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, "Петрочайна дачин тамсаг" ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн хэрэгжилтэд тулгамдаж байгаа асуудлыг судалж, санал боловсруулах, "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах, Дархан, Сэлэнгийн бүсийн "Үйлдвэр технологийн парк"-ийн хөгжлийн төлөвлөгөө болон Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг батлуулан, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах зэрэг хөгжлийн төслүүдийг эрчимжүүлэх чиглэлээр ажлын хэсгүүдийг байгуулах шийдвэрийг гаргасан байна.

6. Үйлчилгээний салбарын өсөлт 2025 оны эхний гурван улиралд 1.3 хувь болж, өмнөх улирлын орчимд хадгалагдлаа. Нийт ачаа эргэлтийн 65 орчим хувь, тээврийн салбарын орлогын 50 орчим хувийг бүрдүүлдэг авто замын тээврийн орлого 3.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 24.2 хувиар буурсан. Үүний голлох нөлөөгөөр тээврийн салбар 6.1 хувиар агшиж, үйлчилгээний салбарын өсөлтийг сааруулав. Авто тээврийн орлого буурахад экспортын нүүрс тээвэрлэдэг зай буурсан нь нөлөөлөв.

¹ Аж үйлдвэрийн салбарт уул уурхай, боловсруулах, цахилгаан, усан хангамжийн салбар орно. Тус хэсэгт уул уурхайн салбараас бусад аж үйлдвэрийн салбаруудыг хамруулан дүгнэв.

² Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд

³ Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд цемент, шохой, бетон, цемент болон гипсээр хийсэн бусад материал, чулуу засах, чулуун тавилга, галд тэсвэртэй бүтээгдэхүүн, барилгын шавран материал зэрэг үйлдвэрлэл орно.

Зам тээврийн салбартай холбоотойгоор 2025 онд хоёр томоохон шийдвэр гаргасан байна. Үүнд:

- **Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль:** Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдэд шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай нөөцийг бүрдүүлэх зорилгоор Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн чуулганаар “Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай” хуулийг 2030 он хүртэл дагаж мөрдөхөөр баталсан. Тус хуулиар стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүнүүдийг тодорхойлсон ба эдгээрт “керосин, дайвар бүтээгдэхүүнээс бусад газрын тосны бүтээгдэхүүн, бүх төрлийн шатахууныг” хамруулжээ. Хуулийн гол зохицуулалт нь:

Засгийн газар: нийлүүлэгч тал газрын тосны бүтээгдэхүүний гадаад захиалга, нийлүүлэлтийг 50 ба түүнээс дээш хувиар бууруулбал дотоодод тухайн бүтээгдэхүүний хомсдол, тасалдал үүсэх нөхцөл бүрдсэн гэж үзэх бөгөөд гадаад эх үүсвэр, захиалга, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заажээ. Үүнд импортын агуулах ба түгээлтэд хяналт тавин хуваарилалт хийх, борлуулалтын хэмжээг тогтоож, шаардлагатай бол улсын болон батлан хамгаалахын нөөцийг зарцуулж нөхөн бүрдүүлэх, өрийн баталгаа гаргах зэрэг бүрэн эрхтэй.

Монголбанк: газрын тосны бүтээгдэхүүний импортын эргэлтийн хөрөнгө болон нөөц нэмэгдүүлэх агуулах, дэд бүтцийн санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр олгох, эсхүл гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авах бүрэн эрхтэй гэжээ.

Ингэснээр Монгол Улсын нэг сарын хэрэглээтэй тэнцэх хэмжээний шатахууны нөөц буюу 200 мянган тонны багтаамжтай нефтийн бүтээгдэхүүн

хадгалах сав (агуулах) болон түүнд агуулагдах нефтийн бүтээгдэхүүнийг худалдаж авахад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой болох юм.

Гэсэн хэдий ч газрын тосны бүтээгдэхүүн болон стратегийн тодотгол бүхий бараа бүтээгдэхүүний импортын бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгох, зах зээлд борлуулагдах газрын тосны бүтээгдэхүүний хэмжээг тогтооход төрөөс оролцох нь тухайн зах зээлийн үйл ажиллагааг гажуудуулах эрсдэлийг дагуулж байна. Мөн алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн эх үүсвэрийг Монголбанкнаас санхүүжүүлэх нь нийт мөнгөний нийлүүлэлтийг зах зээлийн бус зарчмаар нэмэгдүүлэх, улмаар инфляц өсөх дарамтыг бий болгох эрсдэлтэй байна.

Иймд цаашид газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтворжуулж, нөөц бүрдүүлэхэд шатахууны үнийг үе шаттай чөлөөлөх, хилийн боомтуудын дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хувийн хэвшлийн байгууллагууд зах зээлийн шударга зарчмын дагуу худалдаа эрхэлж, ашигтай ажиллах боломжийг бий болгох суурь либералчлалыг хэрэгжүүлэх нь оновчтой.

- **“Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламж ашиглан уул уурхайн бүтээгдэхүүн болон шатахуун тээвэрлэх тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ”-ний өөрчлөлт:** Үүсээд буй геополитикийн зөрчилдөөн, түүнээс үүдэлтэй ОХУ-аас хийж байгаа АИ-92 авто бензиний экспортын хязгаарлалттай холбоотойгоор баруун бүсийн шатахуун нийлүүлэлтийг тогтворжуулах зорилгоор 2025 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн Засгийн газрын 77 дугаар тогтоолоор тус журамд нэмэлт өөрчлөлт оруулж “Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламж ашиглан уул уурхайн бүтээгдэхүүн болон шатахуун тээвэрлэх тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ”-г нэмж баталсан байна.

Тус зохицуулалтаар уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, төмөр замаар тээвэрлэхэд нэвтрүүлэх хүчин чадал хүрэлцэхгүй байгааг харгалзан үзэж, зөвшөөрөгдсөн жин тоннд нийцүүлэн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэж буй тээврийн хэрэгслээс 150 мянган төгрөгийн төлбөр авч олон улс, улсын чанартай авто замаар тээвэр хийлгэхээр тогтсон. Ингэхдээ шатахуун тээврийн хэрэгсэл нь тэнхлэг бүртээ 11 тонн бүхий 6 хүртэлх тэнхлэгтэй (нийт 66 тонн) тээврийн хэрэгслээр зөвшөөрөгдсөн хэмжээг (44 тонн) 22 тонноор хэтрүүлэн шатахуун тээвэрлэх боломжтой болсон байна. Мөн 100 км тутамд 150,000 мянган төгрөгийн төлбөр төлөхөөр тусгажээ.

Хэдийгээр энэ зохицуулалт нь шатахууны нийлүүлэлтийг тогтворжуулах зорилготой байсан ч нөгөө талдаа төлбөр төлөлгүй даац хэтрүүлэн тээвэрлэлт хийж олон салаа зам гаргах, хуурайшилттай үед тоосжилт ихээр үүсгэн бэлчээр талхлах зэргээр байгаль орчинд сөрөг нөлөө бүхий эрсдэл үүсгэх сөрөг нөлөөтэй. Түүнчлэн ийнхүү даац хэтрүүлэн зорчих боломжийг олгосноос үүдэн өмнө нь стандартын дагуу шатахуун тээвэрлэн үйл ажиллагаа явуулдаг байсан аж ахуйн нэгжүүд том оврын тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгжүүдэд зах зээлээ алдан, төрийн шууд оролцооноос үүдэн салбарын гажуудал үүсэх нөхцөл бий болсон байна.

Иймд аж ахуйн нэгжүүд тус шийдвэрийг эсэргүүцэн 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр тайван жагсаал хийж, Зам тээврийн яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай уулзалт хийсний дүнд "Олон улс, улсын чанартай авто замаар замын хөдөлгөөнд оролцох эрх зүйн зохицуулалт болон цаашид гарах үр дагаврын хувьд бусад ачаа тээврийн хэрэгсэл /цемент, барилгын материал г.м/ ачааны хэмжээ хэтрүүлэн тээвэрлэлт хийх боломжийг бий болгох нөхцөл байдал үүсэх, мөн энэхүү тогтоолоор 1 тэнхлэгт ногдох тэнхлэгийн ачааллын хэмжээг 11 тонноор хязгаарласан

боловч энэхүү хязгаарыг эдгээр тээврийн хэрэгсэл мөн хэтрүүлэн тээвэрлэлт хийсээр байгаа тул бүх жингийн дээд хэмжээний хязгаарлалтыг хэвээр мөрдүүлж, цаашид хяналт шалгалтыг сайжруулах нь зүйтэй" гэж үзсэн тул Засгийн газрын 77 дугаар тогтоолын холбогдох хэсгийг хүчингүй болгон өөрчлөлт оруулжээ.

Ингэснээр дээрх өөрчлөлтийг 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 128 дугаар тогтоолоор хийжээ. Хэдийгээр тус өөрчлөлт нь тогтоосон стандарт, зөвшөөрөгдсөн хэмжээг эргээд мөрдүүлэх болсон ч, шатахуун тээврийн баруун бүсийн нийлүүлэлтийг тогтворжуулах хэрэгцээ хэвээр байсаар байх тул хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээс үргэлжлүүлэн даац хэтрүүлэн тээвэрлэх хүсэлтийг хүргүүлсээр байна.

Мөн уг тогтоолтой холбоотой холбогдох бусад заалтуудын хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэж буй тээврийн хэрэгслээс төлбөр авах үйл ажиллагааг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж, улсын төсөв, авто замын санд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар улсын төсөв, авто замын санд 1.0 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

7. Бөөний болон жижиглэн худалдааны салбар 2025 оны эхний гурван улиралд 5.1 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 0.6 нэгж хувиар саарууллаа. Худалдааны салбарын нэрлэсэн борлуулалтын орлого 0.6 хувь болж удаашрав. Нийт салбарын 78 орчим хувийг бүрдүүлж буй хүнсний бус бүтээгдэхүүний худалдааны агшилт болон өнгөрсөн жилийн өндөр суурийн нөлөө голлон нөлөөлөв. Салбарын өсөлт саарсан шалтгааныг нарийвчлан харвал хөдөө аж ахуйн түүхий эд болон мал, амьтдын бөөний худалдаа 62.4 хувиар, машин, тоног төхөөрөмжийн бусад бөөний худалдаа 10.3, шатахууны жижиглэн худалдаа 1.7 хувиар, хатуу, шингэн, хийн түлшний бөөний худалдаа 4.4 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.


Дотоодын худалдаа эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлэх худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 3 дугаар улиралд 45.4 хувь болж, өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар сайжирсан бол өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар доогуур гарлаа.

Мэдээлэл, холбооны салбар 10.0 хувиар, үйлчилгээний бусад салбар 4.2 хувиар тус тус өслөө.

8. Бүтээгдэхүүний цэвэр татвар 2 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 0.3 нэгж хувиар сааруулав. Дотоодын бараа, үйлчилгээ болон импортын бараанаас төвлөрсөн НӨАТ-ын орлого тус тус 9 хувь болон 4 хувиар өсөж, нийт НӨАТ-ын орлого нэмэгдэв. Гэвч НӨАТ-ын буцаан олголт 1.6 дахин нэмэгдсэн, мөн суурийн нөлөө өндөр байсан нь өсөлтийн хурдыг хязгаарлалаа.

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт (нийлүүлэлт талаас)


1. Эдийн засгийн өсөлт дэх салбаруудын оролцоо (нэгж хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт дэх салбаруудын оруулах хувь нэмрийг харуулав.


2. Салбаруудын бодит өсөлт (хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Салбаруудын бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлтийн хувийг харуулав


3. Хөдөө аж ахуй (мянган толгой)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Төл бойжилт, том малын зүй бус хорогдлын хэмжээг харуулав.

4. Эдийн засгийн өсөлт, нэрлэсэн ДНБ (хувь, их наяд төгрөг)



Эх сурвалж: ЭЗХЯ тооцоолол, ҮСХ

Шигтгээ 1. Тогтвортой дэд бүтцийн талаар

Монгол Улсын хөгжлийн бодлогын цөм болох дэд бүтцийн бүтээн байгуулалт нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлд өртөмтгий, өргөн уудам нутаг дэвсгэртэй манай улсад эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь үндэс болж байна. Хэдийгээр ахиц дэвшил гарч байгаа ч дэд бүтцийн мөчлөгийн үе шатуудад бүтэц, зохион байгуулалтын сорилт бэрхшээл болон тулгамдсан асуудал нэлээдгүй байсаар байна. Тухайлбал:

- Төслийн төлөвлөлт, загварчлал үнэлгээ нь нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл, шинжилгээгүйгээр хийгддэг;
- Засвар, үйлчилгээ, арчилгаа тордлогоо төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тогтмол бус шинжтэй;
- Худалдан авалтын үйл явц удаашралтай, сааталтай, тогтмол бус байгаа нь хэрэгжилтийг удаашруулдаг;
- Жилийн төсвийн өөрчлөлт, тодотголууд нь төсвийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийг удаашруулах, цаашлаад тасалдуулдаг;
- Уур амьсгал болон байгаль орчны нөхцөл байдал элэгдэж хуучирсан дэд бүтцийн байгууламжуудын ачааллыг нэмэгдүүлдэг.

Эдгээр нөхцөл байдал нь эдийн засгийн төрөлжилт, бүс нутгийн хөгжил, уур амьсгалын тэсвэртэй байдал болон нийгмийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зэрэг Монгол Улсын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх дэд бүтцийн салбарт хэрхэн нөлөөлж байгааг энэхүү суурь судалгаанд авч үзлээ.

1. Дэд бүтцийн салбарын хэрэгцээ шаардлага:

Тээврийн салбарт:

Монгол Улсын дэд бүтцийн дутагдал ямар цар хүрээнд, хир удаан үргэлжилж буйг тээврийн салбар тодорхой харуулдаг. **Улсын авто замын сүлжээний** урт ойролцоогоор **45,000 км** бөгөөд үүний **14,000 км** гаруй нь хатуу хучилттай. Түүнчлэн, хөдөө орон нутагт буюу аймаг, сумдыг холбосон олон замыг жилийн дөрвөн улирлын турш ашиглах боломжгүй хэвээр байгаа бөгөөд уур амьсгалын эрс тэс нөхцөл байдал нь замын элэгдлийг нэмэгдүүлж байна. Засвар үйлчилгээний давтамж болон удирдлагын тогтолцоо нь чадавхын болон санхүүжилтийн бэрхшээлтэй тулгардаг байна. Хил боомтын олон төрлийн тээврийн сүлжээ хангалтгүй байгаа нь ачаа тээврийн үр ашигтай найдвартай байдалд сөргөөр нөлөөлж байна.

Хэт халалт, эрс хүйтрэлт, хөрс хөлдөх, гэсэх зэрэг үзэгдлийн улмаас үерлэх, зам эвдрэх асуудал дэд бүтцийн сүлжээнд тогтмол тохиолддогийг харгалзан үзвэл, дээрх тэргүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийх нь улсын эдийн засаг болон уур амьсгалын тэсвэртэй байдалд эерэг нөлөөлөх боломжтой.

Улирлын шинжтэй нөхцөлүүд нь дэд бүтцийн сүлжээний өргөтгөл шинэчлэлд хүчтэй нөлөөлсөн хэвээр байна. Өвлийн улиралд ихэнх бүс нутагт хөдөлгөөн хязгаарлагдаж, барилгын ажил зогсоход хүрдэг. Хаврын улиралд үерийн улмаас нам дор газрын коридор, замын хучилт эвдэрч гэмтэх нь ихэсдэг бөгөөд температурын огцом өөрчлөлт нь замын хучилтад ан цав үүсэх, замын чанар муудахад нөлөөлдөг байна. Эдгээр хүчин зүйлс нь ашиглалтын нийт өртгийг нэмэгдүүлж, төслийн төлөвлөлт болон техник-эдийн засгийн үндэслэлд ирээдүйд хийгдэх засвар үйлчилгээний ажлын талаар тусгах хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Эрчим хүчний салбарт:

Монгол Улсын эрчим хүчний салбар нь элэгдэж хуучирсан дэд бүтэц болон нүүрснээс хэт хамааралтай байдлын улмаас бүтцийн шинжтэй бэрхшээлээс нэлээдгүй хамааралтай байна.

- **Цахилгаан болон дулааны** үйлдвэрлэлийн **90 гаруй хувийг нүүрсээр ажилладаг** дулаан, цахилгаан хосолсон станцууд хангаж байна.
- **Сэргээгдэх эрчим хүч** дотоодын нийт үйлдвэрлэлийн дөнгөж **9.41 хувийг** бүрдүүлж байна.
- **Эрчим хүчний алдагдал өндөр** байгаа нь голчлон эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах байгууламж элэгдэж хуучирсан, үр ашиг нь буурсантай холбоотой.
- Өвлийн болон оргил ачааллын хомсдолыг импортын эрчим хүчээр нөхөж байна, тухайлбал нийт цахилгааны **24.6 хувийг** импортолж байна.
- Одоо ашиглагдаж байгаа дулаан-цахилгаан хосолсон станцуудын ихэнх нь анх төлөвлөсөн ашиглалтын хугацаанаасаа хэтэрсэн байна.

Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний нөөц ихтэй:

- **Салхи:** 1.1 ТВ нөөцтэй, жилдээ ойролцоогоор **2,550 ТВц** эрчим хүч үйлдвэрлэх боломжтой.
- **Нар:** жилийн 4,774 ТВц нөөцтэй, жилд 270–300 нарлаг өдөртэй, ойролцоогоор 1,400 КВц/м² эрчим хүчний нөөцтэй, өдөрт 4.3–4.7 КВц/м² нарны эрчимтэй.

Түүнчлэн улирлын шинжтэй нөхцөл байдлууд эрчим хүчний найдвартай байдалд шууд сөрөө нөлөө үзүүлж байдаг. Өвлийн оргил дулааны хэрэглээ сүлжээнд өндөр дарамт үүсгэж, температурын хэлбэлзэл нь хуучирсан дэд бүтцэд эрчим хүчний алдагдлыг нэмэгдүүлдэг. Мөн эрс тэс цаг агаараас үүдэлтэй үерийн гамшиг нь дэд станц болон түгээх шугамуудад нэмэлт эрсдэл учруулдаг байна.

Эдгээр нөхцөл байдал нь салбарын хөрөнгө оруулалтыг цахилгаан дамжуулах болон түгээх дэд бүтцийг шинэчлэн сайжруулж, алдагдлыг бууруулах, эрчим хүчний үйлчилгээний найдвартай байдлыг хангахад нэн тэргүүнд чиглүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Доорх хүснэгтэд 2020–2024 оны эрчим хүчний үйлдвэрлэлийн төрлүүдийг нарийвчлан харууллаа.

Эрчим хүчний үйлдвэрлэлийн төрөл	2020	2021	2022	2023	2024 (ГВц/%)	
Дулаан, цахилгаан хосолсон станц	6493.6	7109.6	7428.5	7755.2	7930.6	90.59
Дизель станц	2.7	1.1	1.2	0.5	0.1	0.00
Сэргээгдэх эрчим хүч	649.4	803	748.9	772.6	823.9	9.41
Нарны станц	108.9	156.9	178.7	193	232.3	2.65
Усан цахилгаан станц	83.3	83.1	61.7	48.1	74.1	0.85
Салхин станц	457.2	563	508.5	531.5	517.5	5.91
Нийт	7145.7	7913.7	8178.6	8528.3	8754.7	100.00

2. Тогтвортой дэд бүтцийг тодорхойлох нь

Ашиглалтын жил удаан (25-50 жил), анхны хөрөнгө оруулалт өндөр болон нийгмийн суурь үйлчилгээг хүргэдэг гэдэг утгаараа дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг оновчтой хэрэгжүүлэх нь нийгэм, эдийн засгийн хөгжилд өндөр ач холбогдолтой. Судалгаагаар дэлхийн нийт хүлэмжийн хийн 60 гаруй хувийг дэд бүтцийн салбар бүрдүүлж байна гэжээ. Иймд дэд бүтцийн салбарыг тэгш хүртээмжтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, тэсвэртэй бөгөөд эдийн засгийн үр ашигтай байлгах дээр анхаарч ажиллах нь чухал юм. Үүнийг дагаад олон улсад тогтвортой дэд бүтцийг сүүлийн арав гаруй жил онцолж, түүнд хөрөнгийн урсгал чиглэх нь ихсэж байна. Тэгвэл олон улсын жишигт тогтвортой дэд бүтцийг дараах дөрвөн хэмжээст ойлголтын хүрээнд авч үздэг байна. Үүнд:

- Эдийн засгийн үр ашиг болон санхүүгийн тогтвортой байдал,
- Байгаль орчин болон уур амьсгалын тэсвэртэй байдал,
- Нийгмийн хүртээмж,
- Засаглалын чанар.

Монгол Улсад одоо үйлчилж буй журам, аргачлалд эдгээр тогтвортой байдлын хэмжээснүүд байгаль орчны хамгаалал болон санхүүгийн хяналтын хэлбэрээр тодорхой хэмжээнд тусгагдсан байдаг. Гэсэн хэдий ч төслийн бэлтгэлийн үе буюу төслийн эхэн үед цогц байдлаар нь тусгахад хүндрэлтэй хэвээр байна. Төслийг тодорхойлох, удирдамж боловсруулах, техник-эдийн засгийн үндэслэл, үнэлгээ болон сонгон шалгаруулалтын үйл явцад эдгээр хэмжээсийг нарийвчлан авч үзээгүйгээс хэрэгжилтийн явцад хүндрэл учрах байдал нэлээдгүй гарч байна.

Тухайлбал байгаль орчны хамгаалал, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлийн эрсдэлийн үнэлгээ, төслийн бүтээн байгуулалтад өртөж байгаа суурьшлын бүс, нутгийн ард иргэдтэй харилцах харилцаа, эдийн засгийн хөгжил, бусад нийгмийн хэрэгцээ шаардлагыг төслийн эхэн үед тодорхой стандартын дагуу цогцоор тусгах нь төслийн хэрэгжилтэд төдийгүй тэднийг хооронд нь жиших, үнэлэх, эрэмбэлэх боломжийг бүрдүүлэх давуу талтай юм.

3. Уур амьсгал ба байгаль орчны гүйцэтгэл

Уур амьсгалын эрсдэл дэд бүтцийн бүх төрлийн төсөлд хүчтэй нөлөө үзүүлж байна. Тухайлбал:

- Үер, ган, зуд болон температурын огцом хэлбэлзэл нь үйлчилгээний тасралтгүй байдалд хүчтэй нөлөөлдөг;
- техник-эдийн засгийн үндэслэлийн хүрээнд уур амьсгалын эрсдэлийн цогц үнэлгээг тусгах нь ховор;
- БОННУ-ний баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлын үзүүлэлтийг тууштай ашигладаггүй.

Тээвэр	Эрчим хүч	Ус, ариун цэвэр	Хотын дэд бүтэц	Хотын дэд бүтэц	
Хэт хүйтэн өвөл (зуд)	Хэт халуун, агаарын өндөр хэм	Үерийн урсгал, ширүүн бороо	Салхи шуурга, шороон шуурга	Мөнх цэвдгийн хайлалт	Ган, усны гачигдал
Тээвэр, эрчим хүчний хангамж, хөдөө орон нутгийн дэд бүтцийн холболтыг тасалдуулдаг	Асфальт, цементийг муутгадаг	Зам, гүүр эвдрэх гол шалтгаан	Суурь фундамент суух, цав үүсэх, бүтцийн өөрчлөлтөд орох	Усан хангамжид нөлөөлнө	Усан хангамжид нөлөөлнө
	Цахилгаан үйлдвэрлэлийн үр ашгийг бууруулдаг	Дэд станц, байгууламж үерт автах	Хоолой, халаалтын шугам сүлжээ, төмөр зам, авто замын эвдрэл	Аж үйлдвэр, цахилгаан станцын ус хөргөлтийг хязгаарлана	Аж үйлдвэр, цахилгаан станцын ус хөргөлтийг хязгаарлана
	Ажилтнуудын аюулгүй байдал, барилгын ажлын хуваарьт нөлөөлдөг	Хотын цэвэрлэх байгууламжийн шугам сүлжээ эвдрэх	Усан хангамжийн бүтцийн эвдрэл		Усны нөөцийн өрсөлдөөн нэмэгдэнэ

ҮТХН 3.0 болон Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөний хүрээнд томоохон зорилтуудыг дэвшүүлсэн боловч тэдгээрийг техник-эдийн засгийн үндэслэл болон төслийн үнэлгээний хэрэгслүүдэд бүрэн тусгаагүй байна. Байгаль орчны суурь мэдээллийн чанарын түвшин жигд бус, авто замын коридор, уул уурхайн үйл ажиллагаа, хот тэлэлтийн нөлөөллийг нийтэд нь үнэлэх дадал туршлага хангалтгүй хэвээр байна.

Уур амьсгалын эрсдэл 2050 он гэхэд нийгэм, эдийн засгийн гол салбаруудад өсөх төлөвтэй байна.

4. Биологийн олон янз байдал

Монгол Улсын экосистемийн доройтол нэмэгдэх төлөвтэй байна. Биологийн олон янз байдлын үндэсний стратеги төлөвлөгөөнд экологийн мэдээллийг төслийн эхний шатанд нэгтгэн тусгахыг онцолдог. Харин одоогийн практикт биологийн олон янз байдлын хүчин зүйлийг төслийн төлөвлөлт, загвар боловсруулах шатны хожуу үед л тусгаж байна. Зэрлэг ан амьтны нүүдлийн зам, амьдрах орчны онцлогийг зам, дэд бүтцийн сүлжээний инженерийн зураг, төсөлд тууштай тусгадаггүй.

5. Дүгнэлт

Хөгжлийн төлөвлөлтийн үе шатуудыг хууль эрх зүйн хүрээнд тогтоосон, төсвийн хүрээ болон бусад төлөвлөлт, хяналтын механизмтай, түүнчлэн, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүрэг тодорхой байгаа зэргээс Монгол Улсад үр ашигтай хөрөнгө оруулалтын тогтолцоог хөгжүүлэх суурь боломж бүрдсэн байгааг тодорхой харж болно.

Хэдий тийм ч энэхүү суурь судалгааны хүрээнд үндэсний, салбарын болон салбар дундын харилцан ялгаатай асуудлуудын хүрээнд олон давтагдаж байгаа дараах тулгамдсан байдлыг тодорхойлсон бөгөөд Монгол Улсын хувьд гол бэрхшээл нь хөрөнгө оруулалтын хэмжээнээс илүүтэйгээр төслийг бэлтгэх, үнэлэх, сонгох, хэрэгжүүлэхтэй холбоотой үе шат, шийдвэр гаргалтын чанартай холбоотой байна.

Стратегийн дараах дөрвөн үр нөлөөллийг тодорхойлсон. Үүнд:

- **Уялдаа холбоо:** Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүргийг уялдуулж, хөрөнгө оруулалтын нэг жилийн нэгдсэн бодлогын хүрээнд хэрхэн уялдаатай ажиллахыг тодорхойлох шаардлагатай байна.
- **Үйл ажиллагааны журам, арга хэрэгсэл:** Шалгаруулалт, техник-эдийн засгийн үндэслэл, үнэлгээний загварт тогтвортой байдлын шалгуурыг нэвтрүүлж, уур амьсгалын эрсдэлийн үнэлгээг төслийн эхний шатанд хийх.
- **Санхүүгийн уялдаа:** Тогтвортой байдлыг харуулсан үнэлгээг Дунд хугацааны төсвийн хүрээтэй холбох.

- **Чадавх ба мэдээлэл:** Уур амьсгалын эрсдэлийн шинжилгээ, төслийг тэргүүлэх чиглэлээр эрэмбэлэх, дижитал хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэх.

Эдгээр өөрчлөлтүүд нь салангид үйл явц бүхий өнөөгийн тогтолцоог илүү уялдаа холбоо сайтай, үндэсний хөгжлийн зорилт болон уур амьсгалын зорилттой нийцсэн хөрөнгө оруулалтын цогц тогтолцоонд шилжих боломжийг бүрдүүлэх юм.

1.2. Эрэлт

9. Өрхийн хэрэглээ болон цэвэр экспорт нийт өсөлтийг дэмжлээ. Эцсийн ашиглалтын аргачлалаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2025 оны эхний 3 улиралд 5.9 хувиар өслөө. Өрхийн хэрэглээ 9.7 хувиар нэмэгдэн, нийт өсөлтийг 7.4 хувиар нэмэгдүүллээ. Мөн барилга, бүтээн байгуулалтын ажлууд эрчимжсэний нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал 18.8 хувиар өсөж, нийт өсөлтийг 6.5 нэгж хувиар нэмэгдүүллээ. Цэвэр экспорт оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлж байсан бол 3 дугаар улиралд цэвэр экспорт 33 хувиар сайжран, оны эхнээс өссөн дүнгээр нийт өсөлтийг 1.3 нэгж хувиар дэмжсэн байна. Харин эргэлтийн хөрөнгө 84.8 хувиар буурч, өсөлтийг 9.1 нэгж хувиар, төрийн хэрэглээ 1 хувиар хумигдаж, өсөлтийг 0.2 нэгж хувиар тус тус буурууллаа.

10. Өрхийн хэрэглээ өсөлтөө хадгаллаа. Өрхийн хэрэглээ хүлээлтээс дээгүүр байж, өмнөх улирлын өсөлтөө хадгалан 2025 оны эхний 3 улиралд 9.7 хувиар тэллээ. Үүнд хүнсний хэрэглээ 5.8 хувиар өссөн бол хүнсний бус бараа, үйлчилгээний хэрэглээ өмнөх оны мөн үеийн түвшнээс 13.5 нэгж хувиар доогуур буюу 11.7 хувиар нэмэгдэн, өсөлт удааширчээ. Тээврийн хэрэгсэл, түүний засвар үйлчилгээ, байр сууц ашиглалт, мах махан бүтээгдэхүүн, боловсролын үйлчилгээ, сүү, сүүн бүтээгдэхүүний зардал хамгийн өндөр дүнгээр нэмэгдсэн бол хувцас, гутал, амралт, аялал, согтууруулах ундааны хэрэглээ хамгийн өндөр дүнгээр буурсан байна. Энэ нь хэдийгээр хэрэглээ өсөлттэй байгаа ч өсөлтөд үнийн өсөлт давамгайлж, өрхүүд нэн шаардлагагүй хэрэглээгээ танаж байх магадлалтай байна.

11. Өрхийн бодит орлогын өсөлт 4.0 хувь болж саарлаа. Өрхийн бодит орлогын жилийн өсөлт 4 хувь болж, өмнөх улирлаас 0.6 хувиар буурч, өсөлт удааширсан байна. Хөдөлмөр эрхлэлт өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар нэмэгдэж, өрхийн цалингийн орлого нэрлэсэн дүнгээр

251.8 мянган төгрөгөөр өсөв. Өрхийн бодит орлогын өсөлтөд цалингийн орлого 4.4 нэгж хувийг бүрдүүлэн голлох нөлөө үзүүлсэн хэвээр байгаа бол тэтгэвэр, тэтгэмжийн орлого нэрлэсэн дүнгээр 30.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн ч бодит дүнгээр өсөлтийг 0.7 нэгж хувиар бууруулсан байна.

Өрхийн нэрлэсэн орлого 2,972 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 354.3 мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 20.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

12. Хөдөө орон нутгийн өрхийн орлого төдийлөн өсөлтгүй хэвээр байна. Нийт өрхийн 52 хувь нь хөдөө, орон нутагт амьдарч байна. Монгол Улсад 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт өрхийн 28.8 хувь буюу 287 мянган өрх 1.6 сая төгрөгөөс бага орлоготой амьдарч байна. ҮСХ-ны 2022 оны ядуурлын тайланд дурдсанаар улсын хэмжээнд 270 мянган өрх ядуу амьдарч буйгаас 185 мянга нь хөдөө орон нутагт байна. Малчдын орлогыг нэмэгдүүлэх, аймаг сумын төвийн иргэдийн амьжиргааг дэмжих бодлого хэрэгжиж байгаа ч Улаанбаатар болон хөдөө орон нутагт амьдарч буй өрхүүдийн орлогын зөрүү 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 4.5 хувиар нэмэгджээ. Тухайлбал, Улаанбаатар болон хөдөөгийн өрхүүдийн дундаж нэрлэсэн орлогын зөрүү өмнөх оны 3 дугаар улиралд 896 мянган төгрөг байсан бол энэ онд 936 мянган төгрөгт хүрсэн байна. Ийнхүү өмнөх улиралд ажиглагдаж байсан орлогын зөрүү багасах хандлага энэ улиралд зогсож, зөрүү эргэн тэлжээ.

13. Үндсэн хөрөнгийн хуримтлал тогтвортой өсөж байгаа бол эргэлтийн хөрөнгө буурсаар байна. Хөрөнгийн хуримтлал нь тайлант хугацаанд эдийн засагт шинээр нэмэгдсэн болон хорогдсон үндсэн болон эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийг харуулдаг. Энэ оны эхний 3 улиралд үндсэн хөрөнгө 18.8 хувиар нэмэгдсэн бол эргэлтийн хөрөнгө 84.8 хувиар буурснаар

нийт хөрөнгийн хуримтлал 5.8 хувиар буурав. Үндсэн хөрөнгийн өсөлтөд орон сууцны бус барилга байгууламжийн нөөц бодитоор 30.1 хувиар, орон сууцны барилга 22.8 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлөв. Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл тогтворжсоноор өмнөх онд бууралттай байсан биологийн өсөж үрждэг хөрөнгө өсөлттэй гарч хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүллээ. Харин уул уурхайн ашигт ажиллагаа саарсны нөлөөгөөр машин тоног төхөөрөмжийн нөөц өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны эхний 3 улиралд нэрлэсэн дүнгээр 2.4 их наяд төгрөгтэй тэнцэж байсан бараа, материал, дусаагүй үйлдвэрлэлийн нөөц энэ оны эхний 3 улиралд 367.4 тэрбум төгрөг болж, буурчээ. Үүнд нүүрсний үнийн бууралттай холбоотой овоолгын үнэлгээ буурсан, худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа удааширч татан авалт багассан зэрэг нөлөөлсөн байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал өмнөх оны мөн үеэс 30.3 хувиар буурсан бол


төсвийн хөрөнгө оруулалт 3.9 хувиар, зээл олголт 16.8 хувиар өсөн нийтдээ хөрөнгийн эх үүсвэрийн өсөлт удааширч байна.

14. Үйлчилгээний экспорт нэмэгдэж, барааны импорт буурснаар эдийн засгийн өсөлтөд үзүүлэх цэвэр экспортын сөрөг нөлөө саарав. Цэвэр экспорт нь бараа, үйлчилгээний экспортын орлого болон бараа, үйлчилгээний импортын зардлын зөрүүгээр илэрхийлэгддэг. Барааны экспорт бодит дүнгээр 2025 оны эхний 3 улиралд 3.1 хувиар буурсан бол үйлчилгээний экспорт 27.6 хувиар өссөнөөр нийт бараа, үйлчилгээний экспорт 2.4 хувиар нэмэгдсэн байна. Мөн барааны импорт бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар буурснаар нийт бараа, үйлчилгээний импортын бодит өсөлт 0.3 хувь болж удааширлаа. Улмаар цэвэр экспортын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөө зогсож, 1.3 нэгж хувийн эерэг хувь нэмэр оруулсан байна.

Зураг 1.2. Бодит ДНБ-ий өсөлт (эрэлт талаас)

1. Эдийн засгийн өсөлт

(нэгж хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Жилийн өсөлтөд оруулсан хувь нэмэр.

2. Өрхийн бодит орлогын өсөлт

(нэгж хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Жилийн өсөлтөд оруулсан хувь нэмэр.

3. Үндсэн хөрөнгийн өсөлт

(нэгж хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Жилийн өсөлтөд оруулсан хувь нэмэр.

1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж

15. Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын ажиллагчдын өсөлт нийт ажиллагчдын өсөлтийг дэмжлээ. 2025 оны гуравдугаар улиралд ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 33 мянгаар нэмэгдэж 1 сая 394 мянгад хүрлээ. Энэхүү өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын өсөлт хадгалагдсанаар салбарын ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 21 мянгаар нэмэгдсэн, уул уурхайн салбарын ажиллагчид өмнөх оны мөн үеэс 20 мянгаар нэмэгдэж түүхэн дээд түвшин буюу 96 мянгад хүрсэн нь нийт ажиллагчдын тооны өсөлтийг голлон тайлбарлаж байна. Түүнчлэн барилга, боловсруулах салбарын ажиллагчид тус тус 13 мянгаар нэмэгдсэн нь өсөлтийг дэмжсэн байна. Харин тээврийн салбарын бууралтын нөлөөгөөр ажиллагчид өмнөх оны мөн үеэс 3 мянгаар буюу 3 хувиар буурч 81 мянга, цахилгаан усны салбарын ажиллагчид 6 мянгаар буюу 20 хувиар буурч 23 мянга, худалдааны салбарын ажиллагчид 12 мянгаар буюу 7 хувиар буурч 175 мянга, үйлчилгээний бусад салбарын ажиллагчид 14 мянгаар буюу 3 хувиар буурч 435 мянгад хүрсэн байна.

Байршлаар авч үзвэл, ажиллагчдын тоо Улаанбаатар хотод өмнөх оны мөн үеэс 17 мянгаар өсөж 641 мянга, хөдөөд 16 мянгаар нэмэгдэж 752 мянга болсон байна. Тодруулбал, ажиллагчдын тоо Хангайн бүсэд 15 мянга, Зүүн

бүсэд 6 мянга, Төвийн бүсэд 2 мянган хүнээр нэмэгдсэн байна. Харин Баруун бүсэд ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 6 мянгаар буурсан үзүүлэлттэй байна.

16. Ажиллах хүчний өсөлт саарснаар ажиллах хүчний оролцооны түвшин буурсан байна. Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 26 мянгаар буюу 1.8 хувиар өсөж 1 сая 474 мянгад хүрэв. Энэхүү өсөлтийн дийлэнх хэсгийг ажиллагчдын тооны өсөлт тайлбарлаж байгаа бол нөгөө талаас ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 8 мянган хүнээр буюу 9 хувиар буурч 81 мянга болсон нь ажиллах хүчний өсөлтийн хурдыг сааруулсан байна. Ажилгүй иргэдийн тоог шалтгаанаар авч үзвэл тухайн жилд сургууль төгссөн, мэргэжил, дадлага туршлага байхгүй шалтгаанаар ажилгүй байсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс нийт 6.3 мянга, ажил хайгаад олдохгүй байгаа иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.4 мянгаар буурсан нь эерэг үзүүлэлттэй байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй шалтгаанаар ажилгүй байсан иргэдийн тоо нийт 2.2 мянгаар буурсан байна.

Ажилгүй иргэдийн тоо буурснаар ажилгүйдлийн түвшин 5.5 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурсан байна. Ажиллах хүчний өсөлт ийнхүү саарснаар ажиллах хүчний

Зураг 1.3. Хөдөлмөрийн зах зээл



оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурч 62.7 хувь болжээ.

17. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам тэллээ.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 29 мянган хүнээр буюу 3.4 хувиар нэмэгдэж 879 мянгад хүрсэн байна. Шалтгаанаар харвал суралцадаг, тэтгэвэрт гарсан, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 27 мянгаар нэмэгдсэн бол мэргэжил, дадлага туршлага байхгүй, мэргэжилд тохирох ажил олдохгүй, тухайн жил сургууль төгссөн, ажиллах сонирхолгүй байсан, байгууллага татан буугдсан, ажил хайгаад олдохгүй байсан зэрэг шалтгаантай иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 4.6 мянгаар буурсан үзүүлэлттэй байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг задлан харвал боломжит ажиллах хүч буюу хөдөлмөр эрхлэх сонирхолтой хэдий ч боломжгүй байсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 6 мянгаар буюу 30 хувиар, бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 23 мянгаар буюу 3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

18. Нэрлэсэн дундаж цалин өссөн хэдий ч хэрэглээний үнийн индексээр засварласан бодит цалингийн өсөлт сул байна. 2025 оны 3 дугаар улиралд дундаж цалин өмнөх оны мөн үеэс 234 мянган төгрөгөөр өсөж 2 сая 714 мянган төгрөг, голч цалин өмнөх оны мөн үеэс 288 мянган төгрөгөөр өсөж 2 сая 312 мянган төгрөгт хүрсэн байна. Харин 2020 оны нэрлэсэн дундаж цалинг суурь болгон тооцвол дундаж цалингийн хэмжээ 114 хувиар өссөн бол худалдан авах чадварыг илэрхийлэх хэрэглээний үнийн түвшнээр засварлагдсан бодит цалингийн өсөлт 2020 оноос хойш 40 хувиар өссөн нь нэрлэсэн цалингийн өсөлттэй харьцуулахад өсөлт сул байна.

Салбараар авч үзвэл, боловсруулах, цахилгааны салбарын цалингийн хэмжээ хамгийн өндөр өсөлттэй байв. Түүнчлэн тээвэр, хөдөө аж ахуй барилга, худалдааны салбарын дундаж цалин өссөн үзүүлэлттэй байна. Харин нөгөө талаас уул

уурхайн салбарын дундаж цалингийн хэмжээ 6 орчим хувиар буурч 4 сая 871 мянгад хүрсэн байна.

19. Хөдөлмөрийн бүтээмжийн улсын дундаж түвшин нэмэгдсэн ч хамгийн өндөр бүтээмжтэй уул уурхайн салбарын бүтээмж дахин буурлаа.

Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс 285 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өсөж, 6 сая 193 мянган төгрөгт хүрлээ. Салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс 584 мянгаар буюу 23 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлттэй байв. Үйлчилгээний салбарын бүтээмжийн түвшин 403 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын бүтээмжийн түвшний өсөлтийг мөн дэмжлээ. Харин уул уурхайн салбарын бүтээмж 953 мянган төгрөгөөр буюу 6 хувиар буурч 14 сая 963 мянган төгрөг болсон нь өмнөх улирлаас өссөн хэдий ч өмнөх оны мөн үеэс буурснаар бүтээмжийн өсөлтийн хурдыг саарууллаа.

20. Шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдлээ.

2025 оны 3 дугаар улирлын байдлаар Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 279.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 29.0 мянгаар буюу 11.6 хувиар нэмэгдлээ. Уг өсөлтийн 60.9 хувийг (17.6 мянга) үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 30.9 хувийг (8.9 мянга) үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүлээ. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл уг 11.6 хувийн өсөлтийн 3.8 нэгж хувийг бөөний болон жижиглэн худалдаа худалдаа эрхлэгчид бүрдүүлж буй бол 3.4 нэгж хувийг үйлчилгээний салбар, 2.2 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байна. Үлдсэн 1.9 нэгж хувийн өсөлтийг боловсруулах үйлдвэр, барилга болон тээврийн салбар агуулж байна (Зураг 1.4).

21. Худалдаа, үйлчилгээний салбарын ААН-ийн тоо нэмэгдэв.

Салбараар харвал, худалдаа, үйлчилгээний салбарт шинээр байгуулагдсан ААН өмнөх оны мөн үеэс 10.6 мянгаар, үйл ажиллагаа явуулж буй ААН 6.1 мянгаар нэмэгдсэн нь ААН-ийн тооны өсөлтийн гол

хэсгийг бүрдүүлж байна. Тодруулбал, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгч шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд 8.9 мянгаар, мэргэжлийн, шинжлэх ухааны салбарын ААН-үүд 1.6 мянгаар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг ААН үүд 1.6 мянгаар, үйлчилгээний бусад үйл ажиллагаа эрхэлдэг ААН үүд 2.4 мянгаар нэмэгдсэн нь гол жинг эзэлж байна.

22. Шинэ хоршоо хөдөлгөөний нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар дахь хоршоодын тоо нэмэгдэв. Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолоор хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хөдөө аж ахуйн салбарт бүртгэлтэй ААН тоо өмнөх оны мөн үеэс 24 хувиар нэмэгдсэн бөгөөд тухайн улирлын өмнөх 10 жилийн дундаж өсөлт болох 8.3 хувиас 3 дахин өндөр өсөлт юм.

23. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй бусад салбаруудын өсөлт саарч байна.

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад уул уурхайн салбарт 47, тээврийн салбарт 544-р нэмэгдсэн бол шинээр байгуулагдсан ААН-ийн тоо уул уурхайн салбарт 171, тээврийн салбарт 834 ААН-ээр нэмэгджээ. Тодруулбал, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 4.0 хувиар нэмэгдсэн нь тухайн улирлын өмнөх 10 жилийн дундаж өсөлт болох 6.3 хувиас 2.3 нэгж хувиар бага байна. Мөн тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 13 хувиар нэмэгдсэн нь тухайн улирлын өмнөх 10 жилийн дундаж өсөлт болох 17.1 хувиас 4.1 нэгж хувиар бага байна.

24. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч жижиг ААН-үүд нэмэгдлээ. Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 115.0 мянган ААН-ийн 86.7 хувь буюу 99.7 мянган ААН 1-9 ажилтантай байна. ААН тоо өмнөх оны мөн

үеэс 8.9 мянгаар нэмэгдсэнээс 8.6 мянга нь 1-9 ажилтантай жижиг ААН байна.

Харин 10-19 ажилтантай ААН 6.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 214 ААН-ээр нэмэгдэхэд хөдөө аж ахуй, үйлчилгээ, боловсруулах салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд нэмэгдсэн нь нөлөөллөө. Мөн 20-49 ажилтантай 59 ААН, 50-аас дээш ажилтантай 19 ААН шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсний гол хэсгийг үйлчилгээний салбар бүрдүүллээ (Хүснэгт 1.3).

Хүснэгт 1.1 Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор

Ажилчдын тооны бүлэг	ААН тоо, мянга	Өөрчлөлт, хувь	Тайлбар
1-9	99.6	9.5%	ААН-ийн тооны өсөлтийн 1/3-ийг үйлчилгээ, 1/3-ийг худалдаа, 12 нэгж хувийг хөдөө аж ахуй болон боловсруулах салбар бүрдүүлсэн.
10-19	6.9	8.8%	Өсөлтийн 46 хувийг үйлчилгээ, 26 хувийг худалдаа, 14 хувийг барилгын салбар бүрдүүлсэн.
20-49	5.3	0.9%	ААН-ийн тоо 59 ААН-ээр нэмэгдсэнээс үйлчилгээний салбар 60 ААН-ээр нэмэгдэж, Барилгын салбараас 4 ААН-ээр буурсан байна.
50-аас дээш	3.0	0.6%	ААН-ийн тоо 19 -ээр нэмэгдсэнээс 23 ААН үйлчилгээ, 3 ААН уул уурхайн салбарт байна. Харин худалдааны салбарт 3 ААН, барилга 5 ААН, ХАА 1 ААН-ээр буурсан байна.
Нийт	111.7	8.3%	

25. ААН-ийн бодит борлуулалтын орлого буурлаа. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар ААН-ийн бодит борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өсөж 25.5 их наяд төгрөгт хүрлээ. Салбараар харвал бөөний болон жижиглэн худалдаа 4.6 нэгж хувийг, уул уурхайн салбарын борлуулалтын орлого 8.1 нэгж хувийг, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 6 нэгж хувийг бүрдүүлж байна.

Зураг 1.4. Аж ахуйн нэгж

Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-ийн тооны өөрчлөлт, салбараар (ААН-ийн тоо)




Эх сурвалж: ҮСХ

Нийт бүртгэлтэй ААН-ийн тоо (мянга)



Эх сурвалж: ҮСХ

ААН-ийн бодит борлуулалтын орлого, III-р улирлын байдлаар (их наяд төгрөг, 2015=100)



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

Шигтгээ 2. Хэрэглэгчийн итгэлийн индекс

2025 оны 3 дугаар улиралд хэрэглэгчдийн ирээдүйн хүлээлт муудаж Хэрэглэгчийн итгэлийн индекс 98.4-д хүрснээр өмнөх оны мөн үеэс 14.3 нэгжээр буурлаа.


Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК) болон Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс тооцон гаргадаг Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ)-ээр эдийн засгийн ерөнхий байдал болон өрхийн санхүүгийн байдлын талаар хэрэглэгчид хэр зэрэг өөдрөг бодолтой байгааг хэмждэг. Хэрэглэгчийн итгэлийн индекс нь Өнөөгийн байдлын индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц/, Ирээдүйн хүлээлтийн индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлого/ гэсэн 2 дэд индекс /5 үзүүлэлтээс бүрдэх/-ээр тооцогдож байна. Ингэхдээ улс даяар санамсаргүй түүврийн аргаар хэрэглэгчдээс санал асуулга авч 0-200-ийн хооронд үнэлдэг бөгөөд индекс 200-д дөхөх тусам хэрэглэгчийн итгэл өндөр, 0-д дөхөх дусам хэрэглэгчийн итгэл сул, харин индекс 100-тай тэнцүү үед эдийн засаг хэвийн байна гэж үздэг.

ХИИ 2025 оны 3 дугаар улиралд 98.4-д хүрэхэд иргэдийн ирээдүйн хүлээлт муудсан голчлон нөлөөллөө. Индексийн үнэлгээг бүрэлдэхүүн хэсгээр задалж Хүснэгт 2-т үзүүлэв.

Өнөөгийн байдлын индекс: Ажлын олдоцын үнэлэмж сайжирсанч Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 2.6 нэгжээр буурсан. Өнөөгийн байдлын индекс нь иргэд эдийн засгийн одоогийн нөхцөл байдлыг бизнесийн нөхцөл болон ажлын олдоц хэр байгаагаар үнэлснээр хэмждэг. 2025 оны 3 дугаар улиралд Өнөөгийн байдлын индекс 127.1-д хүрч нэмэгдэхэд ажлын олдоц “сайн” гэж үнэлсэн иргэд өмнөх оны мөн үеэс 3.7 нэгжээр нэмэгдсэн нь нөлөөллөө. Харин бизнесийн нөхцөлийг “сайн” гэж үнэлсэн иргэд 3.8 нэгжээр буурсан байна.

Ирээдүйн хүлээлтийн индекс: Хэрэглэгчдийн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлт муудаж Ирээдүйн хүлээлтийн индекс өмнөх оны мөн үеэс 20.9 нэгжээр буурлаа. Ирээдүйн хүлээлтийн индекс нь эдийн засгийн ойрын ирээдүйн нөхцөлийг иргэд хэрхэн харж буйг бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлтийн үнэлгээгээр хэмждэг. 2025 оны 3 дугаар улиралд Ирээдүйн хүлээлтийн индекс 89.0-д хүрч буурахад ирэх 6 сард бизнесийн нөхцөл “сайн” болон “муу” байна гэж үнэлсэн иргэд өмнөх оны мөн үеэс тус тус 2.7 6.0 нэгжээр буурсан (нэмэгдсэн) нөлөөллөө. Түүнчлэн, хэрэгдэгчдийн ирэх 6 сарын ажлын олдоц болон орлогын хүлээлт мөн адил гутранги байна. Тухайлбал ажлын олдоц “сайн” байна гэж үнэлсэн иргэд 9.6 нэгжээр буурч, “муу” гэж үнэлсэн иргэд 6.5 нэгжээр нэмэгджээ. Мөн орлого “сайн” байна гэж үнэлсэн хэрэглэгчид өмнөх оны мөн үеэс 5.7 нэгжээр буурч, харин орлого “хэвийн” болон “муу” байна гэсэн иргэд 5 болон 0.2 нэгжээр тус тус нэмэгджээ.

Зураг 1.5. Хэрэглэгчийн итгэлийн индекс улирлаар (2018=100)



Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний (Эн-Ар-Си-Си)

Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийн нөлөөгөөр засварлаж 2018 оны 4 дүгээр улиралд индексийг харьцуулж тооцсон б

Хүснэгт 1.2. Хэрэглэгчийн итгэлийн индекс бүрэлдэхүүн

	2024.III	2025.III	Өөрч.
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ▼			
<i>Бизнесийн нөхцөл</i>			
Сайн	11.9	8.1	-3.8
Хэвийн	38.2	40.9	
Муу	49.0	49.9	0.9
<i>Ажлын олдоц ▲</i>			
Сайн	34.0	37.7	3.7
Хэвийн	33.3	31.3	
Муу	31.1	29.3	-1.8
ИРЭЭДҮЙН ХҮЛЭЭЛТ ▼			
<i>Бизнесийн нөхцөл ▼</i>			
Сайн	17.7	15.0	-2.7
Хэвийн	64.2	58.3	
Муу	15.6	21.6	6.0
<i>Ажлын олдоц ▼</i>			
Сайн	31.8	22.2	-9.6
Хэвийн	51.7	53.7	
Муу	13.4	19.9	6.5
<i>Орлого ▼</i>			
Сайн	25.7	20.0	-5.7
Хэвийн	57.5	62.5	
Муу	15.3	15.1	-0.2

Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв

Шигтгээ 3. Хөдөлмөрийн зах зээлийн цахим хуудаснууд дахь ажлын байрны зарын тоо оны сүүлийн хагаст буурсан байна.

2025 оны гуравдугаар улиралд хөдөлмөрийн зах зээлийн зарим цахим платформуудад нийт 50.8 мянган ажлын байрны зар⁴ нийтлэгдсэн байна. Үүнээс дийлэнх буюу 32.5 мянга нь **zangia.mn** цахим хуудаст, 17.5 мянга нь **unegui.mn** цахим хуудаст, харин цахим хөдөлмөрийн бирж болох **ejob.gov.mn** порталд 774 ажлын байр нийтлэгдсэн байна.

Zangia.mn цахим хуудаст нийт 32.5 мянган ажлын байрны зар нийтлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Салбараар харвал худалдаа болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт зарын тоо хамгийн өндөр өсөлттэй байсан бол үйлчилгээний салбарт нийтлэгдсэн ажлын байрны зар өмнөх оны мөн үеэс 33 хувиар буюу 5.7 мянгаар буурч, 11.6 мянгад хүрсэн нь нийт зарын тоо буурахад голлон нөлөөлжээ. Үүний зэрэгцээ нийтлэгдсэн ажлын байрны зарын дундаж цалингийн хэмжээ 120 мянган төгрөгөөр өсөж 2 сая 209 мянгад хүрсэн байна. Энэхүү өсөлтөд үйлчилгээний салбарын дундаж цалин 754 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бол уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын дундаж цалин буурсан нь нийт өсөлтийг сааруулсан байна.

Харин **unegui.mn** цахим хуудаст нийт 17.5 мянган ажлын байрны зар нийтлэгдсэн бөгөөд үүний ихэнх буюу 56 хувь нь үйлчилгээний салбарт нийтлэгдсэн бол худалдаа, барилгын салбарт нийт 31 хувь нь нийтлэгдсэн нь дийлэнх хэсгийг хамаарч байна. Харин хөдөө аж ахуй болон цахилгааны салбарт ажлын байрны зар нийтлэгдээгүй байна. Нийтлэгдсэн ажлын байрны дундаж цалин 2 сая 222 мянган төгрөг байгаа нь нийт хөдөлмөрийн зах зээлд зарлагдсан улсын дунджаас 325 мянган төгрөгөөр өндөр байна.

Нийт зарлагдсан ажлын байрыг салбараар авч үзвэл, нийт зарын дийлэнх нь үйлчилгээний салбарт (21.6 мянга) зарлагдсан нь нийт зарын 42 хувийг бүрдүүлж байна. бол худалдааны салбарт 9.6 мянга, барилгын салбарт 6.2 мянга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 5.9 мянган ажлын байр тус тус нийтлэгдсэн байна. Харин хөдөө аж ахуй болон цахилгааны салбарт нийтдээ 617 ажлын байрны зар нийтлэгдсэн байна.

Нийт зарлагдсан ажлын байрны дундаж цалин 1 сая 897 төгрөг байсан бөгөөд салбараар нь авч үзвэл уул уурхай болон барилгын салбарууд хамгийн өндөр дундаж цалинтай байв. Тодруулбал, уул уурхайн салбарын дундаж цалин 2 сая 335 мянган төгрөг, хөдөө аж ахуйн салбарынх 2 сая 133 мянган төгрөг байна.

Зураг 1.6. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт

1. Зангиа цахим хуудаст нийтлэгдсэн ажлын байрны зарын тоо, салбараар




2. Ажлын байрны зарын тоо, салбараар



Эх сурвалж: Zangia.mn

3. Ажлын байрны зарын цалингийн хэмжээ (мянган төгрөг)



Эх сурвалж: Хөдөлмөрийн зах зээлийн цахим хуудаснууд

⁴ Энд ажлын байрны зарын тоог цахим хуудануудад нийтлэгдсэн мэдээллээс тоолж гаргасан болно.


1.4. Эдийн засгийн мөчлөг

26. Үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлт потенциал үйлдвэрлэлийн өсөлтийг голлон дэмжсэн хэвээр байна. 2025 оны эхний хагас жилд хаврын цаг агаарын таатай байдлын нөлөөгөөр биологийн өсөж үрждэг хөрөнгө үндсэн хөрөнгийн хуримтлалыг голлон дэмжиж байсан бол энэ оны гуравдугаар улирлаас эхлэн биологийн өсөж үрждэг хөрөнгийн өсөлтийн эрчим суларч, орон сууцны бус барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажлууд үндсэн хөрөнгийн хуримтлалыг голлон дэмжлээ. Үүний нөлөөгөөр потенциал үйлдвэрлэлийн өсөлт 5-6 орчим хувьд буюу өмнөх улирлын орчимд хадгалагдлаа. Мөн хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил алгуур суларч байгаа ч потенциал үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжсэн хэвээр байна.

27. Уул уурхайн салбар сэргэж, боловсруулах, болон үйлчилгээний салбарын идэвх хадгалагдсанаар, нийт үйлдвэрлэл потенциал түвшний орчимд хадгалагдав. 2025 оны эхний хагас жилд уул уурхайн биржийн идэвх суларч, түүхий эдийн экспортын үнэ буурснаар олборлолт буурч, үйлдвэрлэл сөрөг зөрүү нэмэгдээд байв. Харин 2025 оны 3 дугаар улирлаас биржийн идэвх сайжирч, экспортын түүхий эдийн үнэ алгуур өссөнөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл сэргэж, потенциалын орчимд байна. Уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийн зөрүү 2025 оны 3 дугаар улиралд үйлчилгээний салбарын идэвх хадгалагдаж, боловсруулах болон эрчим хүчний салбарын үйл ажиллагаа өмнөх улирлаас эрчимжсэний нөлөөгөөр хаагдлаа. Нийт үйлдвэрлэл потенциал түвшнээс 0.7 хувиар дээгүүр байна.

Зураг 1.7. Үйлдвэрлэлийн зөрүү

1. Потенциал ДНБ-ий өсөлт (хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Потенциал үйлдвэрлэлийг нэг хувьсагчтай шүүлтүүр буюу Ходрик-Прескотт, олон хувьсагчтай шүүлтүүр буюу Калман шүүлтүүр болон үйлдвэрлэлийн функцийн аргачлалаар тус тус тооцов.

2. Үйлдвэрлэлийн зөрүү

(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Үйлдвэрлэлийн зөрүүг бодит болон потенциал ДНБ-ий зөрүүгээр тооцно. Үйлдвэрлэлийн зөрүүг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загварт тулгуурлан олон хувьсагчийн Калманы шүүлтүүрийн аргаар тооцов.

Бүлэг 2

ТӨСВИЙН СЕКТОР

2.1. Төсвийн гүйцэтгэл

2.2. Төсвийн бодлогын төлөв

2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

2. ТӨСВИЙН СЕКТОР

ТОЙМ

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны 3 дугаар улиралд нүүрсний үнэ болон экспортын орлогын бууралтын нөлөөгөөр 20.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.7 их наяд төгрөг буюу 3.1 хувиар буурч, улмаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.3 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн нийт зарлага 22.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар тэлэхэд урсгал зарлагын өсөлт, тэр дундаа төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн өрийн үлдэгдэл 35.7 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.9 их наяд төгрөг буюу 15.9 хувиар өссөн байна. Гадаад өрийн эргэн төлөлт 2025 онд 391.8 сая ам.доллар, 2026 онд 978 сая ам.доллар, 2027 онд 918.5 сая ам.доллар, 2028 онд хамгийн өндөр буюу 1,078.5 сая ам.долларын өрийн төлбөр хүлээгдэж байна.

2.1. Төсвийн гүйцэтгэл

28. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарлаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2025 оны эхний 3 улиралд 22.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.6 их наяд төгрөг буюу 2.7 хувиар буурлаа. Нэгдсэн төсвийн нийт зарлага 22.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өссөнөөр төсвийн нийт тэнцэл 185.8 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.3 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

29. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа харьцангуй идэвхэжсэн хэдий ч нүүрсний үнийн уналтаас шалтгаалан ААНОАТ болон АМНАТ-ийн орлого төвлөрөлт буурч, төсвийн орлого саараад байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны эхний гуравдугаар улирлын байдлаар 20.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.7 их наяд төгрөг буюу 3.1 хувиар буурсан байна. Төсвийн орлого буурахад 2025 оны эхнээс үргэлжилсэн нүүрсний үнийн уналт нь голлох нөлөө үзүүлсэн хэвээр буюу нүүрсний хилийн дундаж үнэ 2025 оны гуравдугаар улирлын байдлаар 57.0 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 40 хувиар буурсан. Экспортын нүүрсний биет хэмжээ сайн байгаа хэдий ч үнийн бууралт нь уул уурхайн салбараас төвлөрөх татварын орлогыг бууруулахад голлон нөлөөлсөн байна.

Тухайлбал 2025 оны эхний гуравдугаар улирлын байдлаар ААНОАТ 3,861.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 917.4 тэрбум төгрөг буюу 19.2 хувиар, АМНАТ-ийн нийт орлого 2,737.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 949.6 тэрбум төгрөг буюу 25.8 хувиар тус тус буурсан нь төсвийн орлогын бууралтад голлох нөлөө үзүүлээ. Манай улсын төсвийн орлогын 30 орчим хувийг уул уурхайн салбараас бүрдүүлдэг бөгөөд гадаад нөхцөл байдал, нүүрсний үнийн бууралт төсвийн орлого төвлөрүүлэлтэд эрсдэл дагуулсан хэвээр байна.

Хүснэгт 2.1. ТОП 100 ААН -ийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төвлөрүүлэлт, салбараар, их наяд төгрөг

ААНОАТ	2024.III	2025.III	Зөрүү	Өсөлт/бууралт
Нийт	3.90	2.87	(1.03)	-27%
Уул уурхай	2.99	1.84	(1.15)	-38%
Санхүү, даатгал	0.52	0.53	0.01	2%
Худалдаа	0.15	0.20	0.05	33%
Үйлчилгээ	0.02	0.02	0.01	46%
Барилга, зам	0.05	0.08	0.03	50%
Боловсруулах үйлдвэрлэл	0.06	0.08	0.02	31%
Тээвэр, агуулах	0.02	0.02	0.00	10%
Цахилгаан, дулаан	0.02	0.02	0.00	13%
Мэдээлэл, холбоо	0.08	0.08	(0.01)	-6%

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

30. Ажиллагсдын тоо нэмэгдсэнээр хөдөлмөр эрхлэлтэд суурилсан татварын орлогыг дэмжин ХХОАТ болон Нийгмийн даатгалын орлого өсөхөд нөлөөллөө. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4,715 төгрөг буюу сард 792 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.” Өмнөх зохицуулалтаар 660 мянган төгрөгийн цалингаас дунджаар 89.1 мянган төгрөг НДШ-д төлдөг байсан бол дээрх шийдвэрээр 106.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөр байна.

Ажиллагсдын тоо нэмэгдсэнээр хөдөлмөр эрхлэлтэд суурилсан татварын орлогыг дэмжсэн байна. Тухайлбал нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчдын тоо 1,092.0 мянга хүрч өмнөх оны мөн үеэс 36 мянгаар буюу 3.4 хувиар өссөнөөр нийт даатгуулагчдын тоо 1,241.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өссөн байна. Харин сайн дураар даатгуулагчдын тоо 149 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар буурсан байна. Үүний үр дүнд 2025 оны гуравдугаар улиралд нийгмийн даатгалын орлого 4.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн

үеэс 645.1 тэрбум төгрөг буюу 19.4 хувиар өссөн бол ХХОАТ 2.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 322.5 тэрбум төгрөг буюу 18.0 хувиар нэмэгдсэн байна.

31. НӨАТ-ын орлого төвлөрөлт өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдаж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 2025 оны гуравдугаар улирлын байдлаар 4.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өссөн нь дотоодын зах зээлийн худалдан авах чадвар харьцангуй тогтвортой байгааг илтгэж байна. Тухайлбал, дотоодын барааны НӨАТ өмнөх оны мөн үеэс 160.7 тэрбум төгрөг буюу 9.1 хувиар, импортын барааны НӨАТ 114.2 тэрбум төгрөг буюу 4.0 хувиар тус тус өссөн байна. Импортын эрэлт саарсан хэдий ч импортын НӨАТ болон импортын гаалийн албан татварын орлого өмнөх оны мөн үеийн түвшинд ойролцоо хадгалагдсан нь НӨАТ-ын орлого төвлөрөлт тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.


32. Суудлын автомашины улсын бүртгэлийн дугаар олгох хязгаарлалттай холбоотойгоор импортын суудлын автомашины тоо хэмжээ

буурч, улмаар онцгой албан татварын орлого буурахад нөлөөллөө. Онцгой албан татварын орлого 2025 оны эхний гуравдугаар улирлын байдлаар 767.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 52.0 тэрбум төгрөгөөр буюу 6.3 хувиар буурсан байна. Уг бууралтад суудлын автомашины онцгой албан татвар 71.3 тэрбум төгрөг буюу 16.3 хувиар буурсан нь голлох нөлөө үзүүлсэн байна. Нийслэлийн Засаг даргын “Нийслэл хотод авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгох шалгуур үзүүлэлтийг батлах тухай” А/1348 дугаар захирамжийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөхөөр заасантай холбоотойгоор оны эхний эхний хагаст суудлын автомашины эрэлт нэмэгдсэн. Харин 2025 оны эхний гуравдугаар улирлын байдлаар импортын суудлын автомашин тоо хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар буурсан хэдий ч үнийн дүн нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл 10 жилээс доош насжилттай он залуу, өндөр үнэтэй суудлын автомашин орж ирсэн хэдий ч тоо хэмжээ буурсан нь суудлын автомашины онцгой албан татварын орлого буурахад голлох нөлөө үзүүлсэн байна.

Зураг 2.1. Төсвийн орлого

1.Төсвийн тэнцэл


(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

2.Татварын орлогын өсөлтөд эзлэх хувь, төрлөөр


(хувь)



Эх сурвалж: Сангийн яам

3.Онцгой албан татварын орлогын өсөлтөд эзлэх хувь, төрлөөр

(хувь)



Эх сурвалж: Сангийн яам

33. Өрхийн орлогыг дэмжих зорилгоор цалин, тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн нь нийт зардлын өсөлтийн голлох шалтгаан боллоо. Төсвийн урсгал зардал 17.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.3 их наяд төгрөг буюу 14.6 хувиар өссөн нь нийт зарлагын өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн бөгөөд нийт зардлын өсөлтийн ойролцоогоор 70 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт дангаараа тайлбарлаж байна. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газраас нийт төрийн албан хаагчдын цалинг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дунджаар 6.0 хувиар нэмэгдүүлсэн, мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтооход баримтлах итгэлцүүрийг 2025 онд шинэчилснээр тэтгэврийн зөрүүг бууруулж, тэтгэврийн зөрүүг бууруулсан сууриас тэтгэврийг 2025 оны 1 дүгээр сараас 6 хувь тус тус нэмэгдүүлсэн нь урсгал зардлын өсөлтөд голлон нөлөөлжээ.

34. Нийгмийн халамжийн зардлын өсөлтөд одонтой эхчүүдэд олгох мөнгөн урамшууллын хэмжээ өмнөх оны мөн үеэс 2 дахин, халамжийн тэтгэмж болон асаргааны мөнгөн тэтгэмж 95 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 2025 оны төсвийн тухай хуулиар 2.5 их наяд төгрөгийн зардал төлөвлөгдсөн бөгөөд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 1.8 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй буюу өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар өссөн байна. Тус өсөлтөд эхийн алдарт одонтой эхчүүдэд олгох мөнгөн урамшуулал 2.0 нэгж хувь, нийгмийн халамжийн тэтгэмж 1.9 нэгж хувь, халамжийн тэтгэвэр 1.7 нэгж хувь, бусад тэтгэвэр, тэтгэмж 0.3 нэгж хувь тус тус нөлөөлжээ.

Засгийн газрын тогтоолоор “Эхийн алдар” одонтой эхэд олгох мөнгөн тусламжийн хэмжээг 2025 оноос эхлэн хоёр дахин нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 66.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 33.9 тэрбум төгрөг буюу 2 дахин өссөн байна.


35. Төсвөөс олгож буй татаасны дийлэнх хувийг нийтийн тээврийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар олголоо. Нэгдсэн төсвөөс 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 659.1 тэрбум төгрөгийн татаас олгосон нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Төрөөс хувийн хэвшилд олгосон татаасны хэмжээ 559.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 41.3 хувиар өссөн хэдий ч төрийн өмчит байгууллагад олгох татаас 60.6 хувиар буурсан байна. Тодруулбал, нийтийн тээврийн алдагдалд олгосон татаас 256.1 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 1.3 дахин, зээлийн хүүгийн татаас 53.6 тэрбум төгрөг болж, 6.7 дахин өссөн байна. Нийтийн тээврээр зорчих үнийг хоёр дахин нэмэгдүүлж өдөрт 1,000 төгрөг болгон цагийн хязгаарлалтгүй дөрвөн удаа зорчих шинэ зохицуулалт 2025 оны нэгдүгээр сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн хэдий ч нийтийн тээврийн алдагдалд олгох төсвийн татаас өсөлттэй хэвээр байна.

36. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс өссөн байна. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардал 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 4.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар өссөн байна. Эдийн засгийн ангиллаар авч үзвэл, хөрөнгө оруулалтын зардлын 71.4 хувийг барилга байгууламж, 15.4 хувийг бусад хөрөнгө, 7.9 хувийг тоног төхөөрөмж, 5.3 хувийг их засварт зарцуулжээ. Барилга байгууламж, их засварын зардал өмнөх оны мөн үетэй харьцуулахад тус тус 21.5 хувь, 28.7 хувиар өсөж, тоног төхөөрөмжийн зардал 20.1 хувиар буурсан байна. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 2025 оны 3 дугаар улиралд нийт 4.9 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөгдсөн хэдий ч 84.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 2.2. Төсвийн зарлага

1. Төсвийн зарлага, эдийн засгийн ангиллаар


(нэгж хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Нэгдсэн төсвийн зарлагын тэлэлтэд эдийн засгийн ангилал тус бүрийн эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс өссөн дүнгээр тооцов.

2. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж зарлагын ангиллаар


(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж зардлын ангиллаар, нэгдсэн төсвийн урсгал зардалд эзлэх хувийг улирлаар тооцов.

3. Төсвөөс олгосон нийт татаасны өсөлт, зориулалтаар

(нэгж хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Нэгдсэн төсвөөс төрийн өмчит болон хувийн байгууллагад олгосон татаасны өсөлтөд зориулалт тус бүрийн эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс өссөн дүнгээр тооцов.

2.2. Төсвийн төлөв

37. Мөчлөг сөрсөн төсвийн хумих бодлого хэрэгжиж байна. Төсвийн бодлого нь мөчлөг сөрсөн шинжтэй буюу эдийн засгийн агшилтын үед төсвийн зарлагыг нэмэгдүүлж, татварыг бууруулах замаар эдийн засгийн идэвхилийг дэмжих, халалтын үед төсвийн зарлагыг бууруулж, орлогын өсөлтөөс хуримтлуулах замаар болзошгүй хямралд урьдчилан бэлтгэх зэрэг эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэх шаардлагатай. Төсвийн бодлого эдийн засгийг тогтворжуулах чиглэлд хэрхэн нөлөөлж байгааг шинжлэх хүрээнд төсвийн тэнцэл дэх төсвийн бодлогын нөлөөг салгаж хардаг. Зураг 2.3-т төсвийн тэнцэлд үзүүлж буй төсвийн бодлогын нөлөөг төсвийн төлөвөөр, төсвийн бодлогоос хамаарахгүй эдийн засгийн мөчлөгийн нөлөөг төсвийн автомат тогтворжуулагчаар ⁵, эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран хуваарийн дагуу төлөх үүрэг хүлээсэн өрийн үйлчилгээний төлбөрийн нөлөөг хүүгийн зардлаар салган харуулав.

Төсвийн нийт тэнцэл 2025 оны 3 дугаар улиралд потенциал ДНБ-ий 1.5 хувьтай тэнцэх

Зураг 2.3. Төсвийн тэнцэл ба төлөв



⁵ Эдийн засаг идэвхжихийн хэрээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа эрчимжсэнээр төсвийн бодлогоос үл хамааран төсвийн орлого нэмэгддэг бол эсрэгээрээ эдийн засгийн уналтын үед татварын орлого буурч, ажилгүйдлийн тэтгэмж

алдагдалтай гарахад төсвийн төлөв 0.1 нэгж хувь, автомат тогтворжуулагч 0.1 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол хүүгийн зардал 1.7 нэгж хувьтай тэнцэх сөрөг нөлөө үзүүлж, төсвийн алдагдлын голлох шалтгаан болсон байна. Өмнөх улиралтай харьцуулахад төсвийн төлөв 0.3 нэгж хувиар суларсан хэдий ч төсвийн хумих бодлого үргэлжилж байна. Инфляц болон төгрөгийн ханш сулрах дарамт өндөр байгаа энэ үед төсвийн хумих бодлого хэрэгжиж байгаа нь мөнгөний бодлогын хандлагатай нийцтэй байгааг харуулж байна.

38. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл сэргэснээр эдийн засгийн идэвхжил нэмэгдэж төсөвт үзүүлэх автомат тогтворжуулагчийн нөлөө эерэг гарлаа. Эдийн засгийн нийт үйлдвэрлэл 2025 оны 3-р улиралд потенциал түвшинд хадгалагдсан нь уул уурхай, тээврийн салбарын өсөлтөөр голлон дэмжигдсэн байна. Улмаар төсвийн бодлогоос үл хамаарах автомат тогтворжуулагчийн нөлөө 2025 оны 3-р улиралд 29.7 тэрбум төгрөг буюу 0.1 нэгж хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Улирлын нөлөө арилгасан сүүлийн дөрвөн улирлын дунджаар тооцов. Хүүгийн зардал болон төсвийн төлөвийг зурагт ойлгомжтой харагдуулах үүднээс (-)-ээр үржүүлсэн болно.

Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Улирлын нөлөө арилгасан сүүлийн дөрвөн улирлын дунджаар тооцов. Үйлдвэрлэлийн зөрүү 0-ээс их (бага) бол эдийн засгийн халат (уналт)-тай үеийг, төсвийн төлөв 0-ээс их (бага) бол тэлсэн (агисан)-г илэрхийлнэ.

2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

39. Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн үлдэгдэл сүүлийн 6 улирал дараалан өсөж, 2025 оны гуравдугаар улирлын байдлаар 35.7 их наяд төгрөгт хүрлээ. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны гуравдугаар улирлын байдлаар 35.7 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39.7 хувьд хүрч, өмнөх улирлаас гадаад зээлийн ашиглалт нэмэгдэж 175.3 тэрбум төгрөгөөр өслөө.

40. Засгийн газрын гадаад өрийн эргэн төлөлт 2026-2028 онд өндөр байна. Нийт гадаад өрийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2025 онд 391.8 сая ам.доллар, 2026 онд 574.3 сая ам.доллар, 2027 онд 831.6 сая ам.доллар, 2028 онд хамгийн өндөр буюу 970.3 сая ам.долларын өрийн төлбөр хүлээгдэж байгаа бол 2029 оноос ачаалал буурч, гадаад өрийн эргэн төлөлт 760.4 сая ам.доллар болж буурахаар байна. Засгийн газрын гадаад өрийн дарамт 2021 оноос тогтвортой буурч ирсэн боловч 2026 оноос өсөх төлөвтэй байгаа тул цаашид валютын нөөцөө нэмэгдүүлэх, ханшийн хэлбэлзлээс үүдэлтэй эрсдэлийг бууруулах, гадаад зээлийг эдийн

засгийн үр өгөөжтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглүүлэх нь чухал байна.

41. Гадаад зээлийн ашиглалт 2025 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 625.3 тэрбум төгрөг байна. Засгийн газрын гадаад зээл, үнэт цаас буюу нийт гадаад өрийн үлдэгдэл 2025 оны гуравдугаар улирлын байдлаар 32.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.4 их наяд төгрөг буюу 7.8 хувиар өссөн байна. Уг өсөлтөд гадаад зээлийн ашиглалт, валютын ханшийн өөрчлөлт голлох нөлөө үзүүлжээ.


Хүснэгт 2.2. Гадаад зээлийн ашиглалт, тэрбум төгрөг

		2025.III
1	Азийн хөгжлийн банк	108.4
2	Австри улс	13.5
3	БНХАУ	321.3
4	Дэлхийн банк	14.0
5	ЕСБХ-ийн банк	6.8
6	Японы ОУХАБ	1.1
7	Польш улс	5.1
8	Солонгос улс	37.7
9	Франц улс	21.7
10	Энэтхэг улс	95.7

Зураг 2.4. Засгийн газрын өр


1.Засгийн газрын өр

(зүүн тэнхлэг: их наяд төгрөг, баруун тэнхлэг: хувь)




Эх сурвалж: Сангийн яам

2.Засгийн газрын өрийн өөрчлөлтийн задаргаа, жилийн өсөлт (хувь)



Эх сурвалж: Сангийн яам, ЭЗХЯ-ны тооцоолол

3.Өрийн үйлчилгээний төлбөрийн динамик (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Олон Улсын Валютын сан
Тэмдэглэл: *ОУВС-гийн төсөөлөл

** 2025 оны батлагдсан хүүгийн төлбөрийн хүлээгдэж буй ДНБ-д эзлэх хувь.

42. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээл сэргэж байна. Засгийн газар 2017 оны аравдугаар сараас хойш дотоод зах зээлд нээлттэй хэлбэрээр дотоод үнэт цаас арилжаалаагүй тул дээрх хугацаанаас хойш дотоод үнэт цаасны үлдэгдэл 48.5 дахин буурч 2024 оны гуравдугаар улиралд 96.8 тэрбум төгрөгт хүрээд байв. Засгийн газрын зүгээс 2024 оны 11 дүгээр сард 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Нийгмийн даатгалын санд 300 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалсан, түүнчлэн Засгийн газар дотоод зах зээлийг дэмжих, төгрөгийн бондын суурь хүүг тогтоох, зах зээлийн гүнзгийрлийг сайжруулах зорилгоор 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр анхдагч зах зээл дээр дотоод үнэт цаас нээлттэй арилжихыг сэргээснээр 2025 оны гуравдугаар улирлын байдлаар 664.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Орон нутгийн зээллэг буюу нийслэлээс 2024 оны дөрөвдүгээр улиралд гаргасан 2.6 их наяд төгрөгийн бонд гаргасан нь нийт Засгийн газрын дотоод өрийн өсөлтөд голлох нөлөөг үзүүлээ.

43. Засгийн газрын өрийн баталгааны нэрлэсэн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар буурч 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 178.8 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь Чойбалсан ДЦС-ыг өргөтгөх төсөлд зориулан Монгол Улсын Хөгжлийн банканд гаргасан Засгийн газрын өрийн баталгаанд хамаарах зээлийн үлдэгдэл юм.


44. Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөвт үндсэн тэнцэл, бодит ДНБ-ий нөлөө өндөр хэвээр байна. Өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөв макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдээс хэр мэдрэг байгааг дүгнэлээ. Өрийн динамик шинжилгээний суурь төсөөллөөр 2025-2026 онуудад харгалзан ДНБ-ий өсөлт 5.5 хувь, 5.7 хувьд, ханшийн сулрал сүүлийн 10 жилийн дундаж түвшинд, ДНБ-ий дефлятор болон үндсэн тэнцэл төсөөллийн орчимд байна гэж үзвэл Засгийн газрын өр 2025

оны эцэст ДНБ-ий 38.8 хувьтай тэнцэхээр байна. Голлох үзүүлэлтүүдэд 2025, 2026 онуудад 1 стандарт хазайлт бүхий шок тооцоход, шокийн нөлөөгөөр 2027 онд Засгийн газрын өр суурь түвшнээс 11.4 хувиар өсөх магадлал харгалзан 25 хувь байна. Энэ нь засгийн газрын өр макро эдийн засгийн тодорхой бус байдал, шокийн нөлөөнөөс ихээхэн мэдрэг байгааг харуулж байна.

45. Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад үндсэн тэнцлийн нөлөө чухал байна.

Зураг 2.5. Засгийн газрын өрийн тогтвортой байдал


1.Засгийн газрын өрд үзүүлэх нэрлэсэн гадаад хүүгийн болон ханшийн сөрөг шокийн нөлөө (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

2.Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс

(өөрчлөлтөд эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлсийг өрийн динамик шинжилгээгээр үнэлэв. Засгийн газрын нэрлэсэн өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 2025 онд 3.4 хувиар буурахад бодит ДНБ-ий өсөлт 2.1 нэгж хувиар эерэг нөлөө үзүүлсэн бол валютын ханшийн сулрал 1.1 нэгж хувьтай тэнцэх сөрөг

нөлөө үзүүлсэн байна. Цаашид Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад ДНБ-ий бодит өсөлт болон үндсэн тэнцлийн алдагдал,

валютын ханшийн хэлбэлзэл голлох үүрэг гүйцэтгэхээр байна.

Бүлэг 3

МӨНГӨНИЙ СЕКТОР

3.1. Инфляц

3.2. Мөнгө ба санхүүгийн салбар

3. МӨНГӨНИЙ СЕКТОР

ТОЙМ

Инфляц 2025 оны 3 дугаар улиралд 9.0 хувь болж, төв банкны зорилтот түвшнээс өндөр хадгалагдлаа. Сүүлийн улирал инфляц эрчимжихэд хүнсний үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Эрэлтийн шалтгаантай инфляц алгуур саарах хандлагатай байсан ч нийлүүлэлтийн гаралтай инфляц мах, хүнсний ногоо зэрэг хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан өсөв. Төв банк мөнгөний бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгаллаа. Арилжааны банкнуудын зээлийн өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсээр байна. Харин банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

3.1. Инфляц

46. Инфляц 2025 оны 3 дугаар улиралд 9.0 хувь болж эрчимжив. Инфляц 2025 оны 9 дүгээр сард 9.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.8 нэгж хувиар тус тус өслөө. Инфляц өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар нэмэгдэхэд орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 1.2 нэгж хувийг, хүнсний бүлэг 0.8 нэгж хувийг, тээвэр 0.7 нэгж хувиар нөлөөлж, голлох хүчин зүйл болсон байна. Инфляцын 2.8 нэгж хувийг хүнсний бараа, 1.9 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, 1.0 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутал, 0.8 нэгж хувийг боловсролын үйлчилгээ бүрдүүлэв. Инфляц 2025 оны 3 дугаар улиралд төсөөллөөс бага зэрэг өндөр гарсан нь цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан хүнсний ногооны үнэ төсөөллөөс өндрөөр өссөнтэй холбоотой байна.


47. Импортын инфляц харьцангуй тогтвортой байгаа бол дотоодын бараа, үйлчилгээний инфляц сүүлийн саруудад эрчимжих хандлагатай байна. Импортын барааны инфляц 2025 оны 9 дүгээр сард 5.1 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар өсөж, нийт инфляцын 26.4 хувийг бүрдүүлэв. Импортын инфляцын 79 орчим хувийг хүнсний бус барааны үнийн өсөлт тайлбарлаж байна. Үүнд хувцас, бөс бараа, гутал, автомашин, шатахууны үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Импортын инфляц харьцангуй

тогтвортой хадгалагдахад ханшийн зах зээл тогтворжсон нь эергээр нөлөөлөв. Дотоодын бараа, үйлчилгээний инфляц 2025 оны 9 дүгээр сард 12.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.2 нэгж хувиар эрчимжиж, нийт инфляцын 73.6 хувийг бүрдүүлсэн байна. Дотоодын инфляцад хүнс болон үйлчилгээний үнийн өсөлт голлох нөлөөтэй байна. Тухайлбал, 2025 оны 9 дүгээр сард үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 6.5 нэгж хувиар нэмэгдэж, инфляцын 3.7 нэгж хувийг бүрдүүлжээ. Үйлчилгээний үнийн өсөлт өмнөх оноос эрчимжихэд өрхийн цахилгааны төлбөр, орон сууцны түрээс, нийтийн тээвэр болон шүдний эмнэлгийн үйлчилгээний үнэ өссөн нь нөлөөлжээ.

48. Эрэлтийн инфляц сүүлийн 6 сар дараалан саарсан бол нийлүүлэлтийн шалтгаантай инфляц эрчимжлээ. Хүнс, шатахуун, түлш, эрчим хүчийг хасаж тооцсон эрэлтийн (суурь) инфляц 2025 оны 9 дүгээр сард 7.8 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар эрчимжсэн бол өмнөх улиралтай харьцуулахад 0.9 нэгж хувиар саарсан байна. Эрэлтийн инфляц сүүлийн 6 сар дараалан буурсан үзүүлэлттэй байна. Эрэлтийн инфляц саарахад 2025 оны төсөвт тодотгол хийж, төсвийн урсгал зардлыг бууруулсан, ханшийн зах зээл тогтворжсон, хэрэглээний зээлд

Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн


1.Инфляц ба зорилтот түвшин



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Улирлын инфляцын хувь хэмжээг улирлын сүүлийн саруудаар тооцов.


2.Инфляцын бүрэлдэхүүн



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Инфляцыг бүлгүүдээр задлан харуулав.

3.Суурь инфляц



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Суурь инфляцыг хүнс, шатахуун ба хатуу түлшийг нийт инфляцаас хасаж тооцов.

зохицуулалт хийсэн, бодлогын хүүг 12 хувьд хадгалсан зэрэг бодлогын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн нь голлон нөлөөллөө. Эрэлтийн инфляц нийт инфляцын дийлэнх хэсгийг буюу 4.8 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц 2025 оны 9 дүгээр сарын байдлаар 11.0 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 5.7 нэгж хувиар эрчимжсэн байна. Нийлүүлэлтийн инфляц эрчимжихэд өрхийн цахилгааны тариф өмнөх оны мөн үеэс 65 хувиар, хүнсний барааны үнэ 10.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

49. Хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц алгуур буурах хандлагатай байсан бол хүнсний инфляц өсөх хандлагатай байв. Хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 8.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар өссөн бол өмнөх улирлаас 0.8 нэгж хувиар буурсан байна. Хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц өмнөх оноос өсөхөд өрхийн цахилгааны төлбөр 65 хувиар, автобусны билетийн үнэ 100 хувиар, орон сууцны түрээс 35 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 6.2 хувиар, АИ-92 бензиний үнэ 7.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Хүнсний барааны инфляц 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 10.6 хувьд хүрч,


өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар эрчимжив. Нийт инфляцын 2.8 нэгж хувийг дангаар бүрдүүлсэн хүнсний инфляц өсөхөд мах, махан бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үнийн өсөлт голчлон нөлөөллөө. Тодруулбал, мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар, хүнсний ногооны үнэ 28.7 хувиар тус тус өссөн байна. Хүнсний ногооны үнийн өсөлтөд цаг агаарын нөлөөгөөр хураасан ургац өмнөх онтой харьцуулахад 15.2 хувиар буурсан нь нөлөөллөө.

50. Олон улсад чингэлэг тээврийн үнэ өмнөх оны мөн үеэс буурсан бол хүнсний үнийн индекс өссөн байна. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис дэх Суэцийн сувагт үүссэн халдлагын нөлөөгөөр 2024 оны 2 дугаар сараас хойш эрчтэй өсөөд байсан бол 2024 оны 8 дугаар сараас аажмаар буурч эхэлсэн. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ 2025 оны 9 дүгээр сарын эцсийн байдлаар 40 фут чингэлэг тутам 1,761 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 52.3 хувиар буурсан бол цар тахлын өмнөх үеэс 26 хувиар өндөр байна.

Хүнсний үнийн индекс 2025 оны 3 дугаар улирлын эцэст 128.7 болж, өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар өслөө. Дэлхийн зах зээл дээр махны үнэ өссөн бол үр тариа, сүүн бүтээгдэхүүн, элсэн

Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс


1.Бодлогын хүү ба Тэйлорын хүү



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Тэйлорын дүрмээр тооцсон хүү нь бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх бөгөөд өмнөх улирлын бодлогын хүү, инфляц, инфляцын хүлээлт, нэрлэсэн хүү зэрэг хувьсагчдыг агуулсан тэгшитгэл юм.

2.Мөнгөний нөхцөлийн индекс



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Мөнгөний нөхцөлийн индекс нь эдийн засаг дах мөнгөний бодлогын нөлөөг хэмжих үзүүлэлт юм. Мөнгөний нөхцөлийн индексийг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP арга зүйг ашиглан тооцоолов.

чихэр болон ургамлын тосны үнэ буурсан байна. 2025 оны 9 дүгээр сарын байдлаар Хятад, Орос, Солонгос, Япон, Киргизстан, Туркийн инфляц буурсан бол Казакстан, Шри-Ланк, Гүрж, Америк, Их Британи болон Евро бүсийн инфляц өссөн байна.


51. Бодлогын хүү зохистой түвшинд байна. Төв банк 2025 оны 3 дугаар улирлын турш бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгаллаа. Бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх Тэйлорын дүрмээр тооцсон хүү 12.1 хувь байгаа нь бодлогын хүүний дундаж түвшинтэй нийцтэй байна. Түүнчлэн 2025

оны 2 дугаар улирлаас эхлэн бодит хүүний зөрүү мөнгөний нөхцөлийг бага зэрэг чангаруулах нөлөөтэй байна. 2025 оны 3 дугаар улиралд бодит ханшийн зөрүүний мөнгөний нөхцөлийг чангаруулах нөлөө өмнөх улиралтай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.


Цаашид шинээр олгосон зээлийн өсөлт, геополитикийн тогтворгүй байдал, тарифын бодлого зэрэг инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлүүд хэвээр хадгалагдаж байгаа тул бодлогын хүүг богино хугацаанд бууруулахгүй байх нь тохиромжтой байна.

Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ


1.Хонины мах (кг/төгрөг)




2.Үхрийн мах (кг/төгрөг)




3.Гурил, 1-р зэрэг (кг/төгрөг)




4.Талх, Атар (төгрөг)




5.Ургамлын тос (төгрөг)




6.Төмс (төгрөг)



7.Сүү, савласан (литр/төгрөг)



8.Дизель түлш (литр/төгрөг)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Голлох зарим бүтээгдэхүүний үнийн динамикийг сараар харуулав.


3.2. Мөнгө ба санхүүгийн салбар

52. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн улирал эрчимжих хандлагатай байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2025 оны 3 дугаар улирлын эцэст 6.2 хувьд хүрч, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 18.2 нэгж хувиар буурлаа. Эх үүсвэр талаас төгрөгийн хадгаламж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон бүрдүүлж байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 6.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.0 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.6 нэгж хувийг гадаад валютын харилцах бүрдүүлсэн бол төгрөгийн харилцах 3.7 нэгж хувиар, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.2 нэгж хувиар тус тус бууруулах нөлөө үзүүлээ. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 6.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.0 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.6 нэгж хувийг гадаад валютын харилцах бүрдүүлсэн бол төгрөгийн харилцах -3.7 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлээ. Байршуулалт талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 8.7 нэгж хувийг дотоод цэвэр актив бүрдүүлсэн бол гадаад цэвэр актив 3.1 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлжээ. Дотоод цэвэр активын өсөлтөд дотоодын зээл голлон нөлөөлж байна.

53. Зээлийн өсөлт үргэлжлэн саарлаа. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 3 дугаар

улирлын эцэст 42.7 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 22.1 хувьд хүрлээ. Нийт зээлийн үлдэгдлийн 70 хувь буюу 29.7 их наяд төгрөгийг бизнесийн зээл, 30 хувь буюу 13.0 их наяд төгрөгийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Бизнесийн зээлийн үлдэгдлийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 25.0 хувь болж, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 9.2 нэгж хувиар саарсан байна. Бизнесийн зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдааны зээл өмнөх оны мөн үеэс 31.2 хувиар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зээл 20.1 хувиар, барилгын зээл өмнөх оны мөн үеэс 36.4 хувиар, хөдөө аж ахуйн зээл 41.5 хувиар тус тус өссөн нь голчлон нөлөөлжээ. Хэрэглээний зээлийн үлдэгдлийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 16.0 хувьд хүрч, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 21.4 нэгж хувиар саарав. Цалингийн зээл хэрэглээний зээлийн өсөлтөд голлох нөлөөтэй хэвээр байна. Тодруулбал, цалингийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өсжээ. Мөнгөний бодлогын хорооноос 2025 оны 7 дугаар сард тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн зохицуулалтыг хүчингүй болгож, шинээр олгох зээлд өр, орлогын харьцаа мөрдөхгүй болсноор тэтгэврийн зээлийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 42.2 хувьд хүрч эргэн эрчимжлээ.

Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

54. Шинээр олгосон зээлийн өсөлт бизнесийн зээлийн хувьд харьцангуй өндөр хэвээр байгаа бол хэрэглээний зээлийн өсөлт саарах хандлагатай байна. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар банкны салбарын шинээр олгосон зээлийн нийт хэмжээ 48.9 их наядад хүрч, өмнөх онтой харьцуулахад 7.0 их наяд төгрөгөөр буюу 16.8 хувиар өслөө. Үүнээс 65.6 хувийг бизнесийн зээл, 34.4 хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. 2025 оны эхний 3 улирлын байдлаар шинээр олгосон бизнесийн зээлийн жилийн өсөлт 21.8 хувьд хүрч, өсөлтийн хурд 23.3 нэгж хувиар саарлаа. Бизнесийн шинээр олгосон зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа, уул уурхай, олборлолт, барилга, боловсруулах үйлдвэрлэл, болон санхүү, даатгалын үйл ажиллагааны салбаруудад зээл олголт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Харин шинээр олгосон хэрэглээний зээлийн өсөлт 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 8.3 хувь болж, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 23.4 нэгж хувиар буурчээ. Шинээр олгосон хэрэглээний зээлийн өсөлтийг хадгаламж барьцаалсан зээл болон тэтгэврийн зээл голлон бүрдүүлж байна. Төв банкнаас тэтгэвэр, тэтгэмж барьцаалсан зээлийн хувьд мөрдөж байсан зохицуулалтыг 2025 оны 7 дугаар сард хүчингүй болгосон. Ингэснээр 2025 оны 3 дугаар улиралд олгосон тэтгэврийн зээл өмнөх улиралтай


харьцуулахад 1.2 их наяд төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

55. Чанаргүй зээлийн хэмжээ өслөө. Чанаргүй зээлийн нийт хэмжээ 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар нэмэгдсэн байна. Чанаргүй зээлийн 21.3 хувийг цалин, 15.9 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 14.4 хувийг барилга, 12.6 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 11.3 хувийг уул уурхай, олборлолтын зээл бүрдүүлж байна. Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэхэд чанаргүй цалингийн зээл өмнөх оны мөн үеэс 157.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн өрхийн хэрэглээнд зориулсан чанаргүй зээлийн үлдэгдэл 297 хувиар өссөн нь сөрөг нөлөөтэй байна. Харин уул уурхайн салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.8 хувиар буурлаа. Улмаар чанаргүй зээлийн нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь 5.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурсан бол өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Зээлийн чанар өмнөх улирлаас муудахад чанаргүй цалингийн зээл 20.7 хувиар болон уул уурхайн зээл 13.5 хувиар тус тус өссөн нь голчлон нөлөөллөө.

56. Нийт хадгаламжийн өсөлтийн дийлэнхийг иргэдийн төгрөгийн хадгаламжийн өсөлт бүрдүүлж байна. Банкнуудын нийт хадгаламж 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 28.5 их наяд


Зураг 3.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд

1.Хадгаламжийн өсөлт (хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

2. Банк хоорондын захын хүү болон шинээр татсан хадгаламжийн хүү (хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

3.Бодит үйлчилж буй хүү (хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

Тэмдэглэл: Бодит үйлчилж буй хүү=(1+Зарласан хүүгийн хувь/хүү бодох давтамж)^ (Хүү бодох давтамж)-1

төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар өслөө. Үүнээс иргэдийн хадгаламж 23.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар өссөн байна. Тодруулбал, иргэдийн төгрөгийн хадгаламж 20.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.8 хувиар өссөн бол иргэдийн валютын хадгаламж 3.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар өслөө. Харин байгууллагын нийт хадгаламж 4.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар тус тус өссөн байна. Төгрөгийн шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 11.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өссөн бол валютын хадгаламжийн хүү 4.8 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар өсжээ. Иргэдийн төгрөгийн хадгаламж өсөлттэй хэвээр байгаа ч өсөлтийн хурд саарах хандлагатай байна.

57. Активын долларжилтын түвшин өмнөх оны мөн үеэс өслөө. Гадаад валютын харилцах ба хадгаламжийн мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хэмжээ 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 23.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар тус тус өссөн байна. Активын долларжилтын түвшин өмнөх оны мөн үеэс буурахад гадаад валютын хадгаламж 18.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

58. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү бодлогын хүүний орчимд байна. 2025 оны 3 дугаар улиралд мөнгөний бодлогын хүү 12 хувьд хадгалагдсан бол банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү мөн 12 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.8 нэгж хувиар өссөн бол өмнөх улиралтай харьцуулахад өөрчлөлтгүй байна.

59. Зээл ба хадгаламжийн бодит үйлчилж буй хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс буурлаа. Арилжааны банкнуудын бодит үйлчилж буй зээлийн хүү 2025 оны 3 дугаар улиралд 17.9 хувь

болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар өсжээ. Харин бодит үйлчилж буй хадгаламжийн хүү 12.8 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар тус тус өссөн байна. Зээл ба хадгаламжийн бодит үйлчилж буй хүүний зөрүү өмнөх оноос 0.6 нэгж хувиар буурлаа. Бодит үйлчилж буй хүүний зөрүү өмнөх оноос буурахад хадгаламжийн хүү зээлийн хүүнээс өндрөөр өссөн нь нөлөөлөв.

60. Зээлийн тэлэлт сэргэх хандлагатай байна. 2025 оны 3 дугаар улиралд нийт зээл дотоодын нийт бүтээгдэхүүний⁶ 47.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8 нэгж хувиар өссөн байна. Зээлийн тэлэлт 2022-2023 онд саарсан байсан бол 2023 оны сүүлийн хагасаас сэргэж эхэллээ. Мөн банкны салбарын нийт зээл ба хадгаламжийн харьцаа 2025 оны 3 дугаар улиралд 1.5 (150 хувь) болж, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өссөн бол өмнөх улирлаас 0.03 нэгж хувиар буурлаа. Уг харьцаа өсөхөд банкны салбарын зээлийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Зээл ба хадгаламжийн харьцаа өндөр болсноор хөрвөх чадварын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

61. Банкны салбарын ашигт ажиллагаа эерэг хэвээр байгаа боловч сүүлийн улирлуудад саарах хандлагатай байна. Тухайлбал, банкны салбарын активын өгөөж 2025 оны 3 дугаар улиралд 1.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурлаа. Хэдийгээр банкны салбарын активын өгөөж өмнөх оны мөн үеэс бууралттай байгаа ч эерэг хадгалагдаж, банкны салбар ашигтай ажиллаж байна. Харин активын өгөөж өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурахад чанаргүй зээлийн хэмжээ өссөн нь нөлөөлсөн байж болзошгүй байна.

62. Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдлийн өсөлт өндөр хэвээр байна. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 577 банк бус

⁶ ЭЗХЯ-ны нэрлэсэн ДНБ-ий 2025 оны төсөөллийг ашиглав.

санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт зээлийн хэмжээ 7.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 34.1 хувиар өссөн байна. Нийт олгосон зээлийн 92.8 хувийг иргэдэд, 7.2 хувийг хуулийн этгээдэд олгосон зээл бүрдүүлжээ. 2025 оны 3 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлдэгчдийн 93.2 хувь

буюу 2.6 сая харилцагч финтек зээлийн үйлчилгээгээр нийт 2.1 их наяд төгрөгийн зээл авсан байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жинлэсэн дундаж хүү сарын 3.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсжээ.

Хүснэгт 3.1. Санхүүгийн салбарын эмзэг байдал

		Зээлийн тэлэлт	Хөрөнгийн чанар	Ашигт ажиллагаа	Төлбөр гүйцэтгэх чадвар	Хөрвөх чадвар
		Нийт зээл/ДНБ	Чанаргүй зээл/Нийт зээл	Банкны активын өгөөж	Зээл/Хадгаламж	Хөрвөх актив/Богино хугацаат өр төлбөр
2020	I	44.8	10.8	0.3	123	40.9
	II	45.4	11.1	1.2	114	38.1
	III	45.4	11.4	1	104	38.6
	IV	45	11.8	0.5	95	48.0
2021	I	39.1	11.5	1.1	95	48.0
	II	42.4	10.3	2.2	100	53.3
	III	44.8	9.9	1.5	105	48.8
	IV	46.2	10	0.7	110	53.3
2022	I	39.9	9.7	2	123	44.2
	II	42.4	9	3.5	128	45.1
	III	41.5	11.2	1.3	134	42.0
	IV	40.1	9.2	2.8	127	56.7
2023	I	32.3	9.6	2.4	122	48.3
	II	35.6	8.7	2.7	131	49.0
	III	36.3	8.5	2.4	131	50.7
	IV	38.1	7.5	2.6	124	57.8
2024	I	36.1	7.1	2.8	129	57.2
	II	41.5	5.9	3.4	139	51.7
	III	43.7	5.7	2.3	141	49.2
	IV	45.9	5.1	2.6	139	52.0
2025	I	42.9	5.3	2.4	144	49.2
	II	46.9	4.9	2.1	153	43.2
	III	47.5	5.2	1.6	150	43.3

Тэмдэглэл: Хөрвөх активыг касс дахь бэлэн мөнгө, төв банк дахь харилцах ба хадгаламж (төгрөг, валют), төв банкны үнэт цаас болон төв банк дахь бусад хадгаламжийн нийлбэрээр тооцов. Богино хугацаат өр төлбөрт харилцах болон хугацаатай хадгаламж, бусад санхүүгийн байгууллагуудын, банк хоорондын, гадаадын байгууллагын, болон төрийн байгууллагын өр төлбөрөөр тооцсон болно. Нийт зээл ба ДНБ-ий харьцааг тооцоход ЭЗХЯ-ны 2025 оны нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөллийг ашиглав.ту
Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

Бүлэг 4

ГАДААД СЕКТОР

4.1. Гадаад худалдаа

4.2. Төлбөрийн тэнцэл, гадаад өр

4. ГАДААД СЕКТОР

ТОЙМ

Зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдсан нь үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг харуулж байна. Гэсэн хэдий ч дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал түүхэн дээд түвшинд хүрч, эрэлт буурсны улмаас нүүрсний үнэ огцом унасан нь экспортын орлогод голлох сөрөг нөлөө үзүүлэв. Нөгөө талаар дотоодын эрэлт саарснаар импортын өсөлт хязгаарлагдмал байв. Гэсэн хэдий ч экспортын орлогын бууралт илүү хүчтэй байсан тул урсгал дансны алдагдал тэлж, төлбөрийн тэнцэлд дарамт нэмэгдлээ.

4.1. Гадаад худалдаа

63. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан хэдий ч худалдааны эргэлт өмнөх оны мөн үеэс буурлаа. Монгол Улс 2025 оны гуравдугаар улирлын байдлаар дэлхийн 154 улстай худалдаа хийж, худалдааны тэнцэл 2.2 тэрбум ам.долларын ашигтай гарсан хэдий ч нийт бараа эргэлт 19.2 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буурлаа.

64. Экспортын орлогын өсөлт саарлаа. 2025 оны эхний гурван улирлын байдлаар Монгол Улсын экспорт 10.7 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар буурсан байна. Энэ бууралтад олон улсын зах зээл дээрх нүүрсний үнийн уналт болон алтны экспортын биет хэмжээ буурсан нь голлон нөлөөлжээ. Цаашид экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ өндөр түвшинд тогтвортой хадгалагдах төлөвтэй байгаа хэдий ч зэсийн баяжмалаас бусад голлох бүтээгдэхүүний хилийн үнэ гадаад орчны нөлөөгөөр буурахаар хүлээгдэж байна.

65. Нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч гадаад орчноос шалтгаалан хилийн үнэ буурлаа. БНХАУ-ын коксжих нүүрсний олборлолт нэмэгдсэнээс гадна гангийн томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний татан авалтаа удаашруулсан нь манай улсын нүүрсний экспортод сөргөөр нөлөөллөө. Үүний үр дүнд 2025 оны эхний гурван улирлын байдлаар


нүүрсний экспорт 62.6 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар нэмэгдсэн хэдий ч хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 40 хувиар буурлаа. Улмаар нүүрсний экспортын орлого 44 хувиар буурч, нийт экспортын өсөлтөд сөрөг нөлөө үзүүллээ. Цаашид, гадаад орчин дэх нүүрсний эрэлт тогтвортой байж биет хэмжээ нэмэгдэх хэдий ч хилийн үнэ сэргэх төлөвгүй байна.

66. Зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын хэмжээ нэмэгдлээ. 2025 оны эхний гурван улирлын байдлаар зэсийн баяжмалын экспорт 1,647 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 38 хувиар, төмрийн хүдрийн экспорт 6,485 мянган тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 18 хувиар тус тус өссөн байна. Энэхүү өсөлт нь олборлолт нэмэгдсэн болон дэлхийн зах зээл дэх зэсийн эрэлт өндөр түвшинд хадгалагдаж байгаагаас шалтгааллаа. Цаашид зэсийн баяжмал болон төмрийн хүдрийн олборлолт тогтвортой нэмэгдэх төлөвтэй бөгөөд цэвэр зэсийн дэлхийн зах зээл дэх үнэ өсөх хандлагатай байна.

67. Экспортын хоригоос шалтгаалан зарим малын гаралтай бүтээгдэхүүний экспорт буурлаа. Улирлын нөлөөгөөр 2025 оны эхний хагас жилийн байдлаар ноолуурын экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 хувиар буурсан байна. Мөн боловсруулах үйлдвэрлэлийн идэвх

Зураг 4.1. Экспорт

1. Экспортын жилийн өсөлт (нэгж хувь)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2. Экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ

Бүтээгдэхүүн	2024.09	2025.09	Өсөлт
Зэсийн баяжмал /мян.тонн/	1,186	1,647	38%
Нүүрс /сая тонн/	61.2	62.6	2.3%
Алт /кг/	9.0	6.8	-25%
Төмрийн хүдэр /мян.тонн/	5,461	6,485	18%
Газрын тос /мян. баррель/	3,100	2,679	-14%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

3. Уул уурхайн бирж дээр амжилттай болсон арилжааны тоо



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

сул байсантай холбоотойгоор арьс ширний экспорт 45 хувиар тус тус буурчээ.

68. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны идэвх суларлаа. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний гурван улирлын байдлаар 12.5 сая тонн нүүрсийг 851 сая ам.доллороор, 4,152 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 257 сая ам.доллороор, 31.7 мянган тонн зэсийн баяжмалыг 70 сая ам.доллороор тус тус арилжаалаад байна. 2024 оны гуравдугаар улирлаас эхлэн арилжааны идэвх тасралтгүй буурсаар 2025 оны хоёрдугаар улиралд 85 арилжаа болж буураад байсан. Харин Засгийн газраас экспортын нэмэгдүүлэхтэй холбоотой (шигтгээ..) арга хэмжээ хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор 2025 оны 3 дугаар улирлаас уул уурхайн биржийн арилжаа буцаад сэргэж эхэллээ.

69. Импортын эрэлт суларлаа. 2024 онд эдийн засгийн идэвхжил өндөр байж, өрхийн орлого, зээл олголт нэмэгдсэнээр иргэд, аж ахуй нэгжийн худалдан авах чадвар сайжирч импортын бараа, бүтээгдэхүүний урсгал өндөр байв. Харин 2025 оны 3 дугаар улиралд импорт өмнөх оны мөн үеэс 74 сая ам.доллар буюу 0.9 хувиар буурч, импортын эрэлт сулав.

70. Импортын жилийн өөрчлөлтийг барааны бүлгээр авч үзвэл: нийт импортын өсөлтөд хэрэглээний бүтээгдэхүүн 1.5 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол, хөрөнгө оруулалтын зориулалттай машин механик тоног төхөөрөмж, барилгын материал -0.9 нэгж хувь, аж үйлдвэрийн орц -1.4 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна.

71. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өндөр хэвээр байна. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 3.1 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 4 хувиар өсөв. Уг өсөлтөд суудлын автомашин болон хүнсний бүтээгдэхүүний

импорт голлох нөлөөг үзүүллээ. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар өрхийн хүнсний хэрэглээ нэмэгдэж, хүнсний бүтээгдэхүүний импорт 5.5 хувиар өслөө. Харин суудлын машины импорт 2025 оны эхний хагас жилд ихээхэн өсөлттэй байсны нөлөөгөөр 3 дугаар улиралд 861 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 7 хувиар өслөө. 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 10-аас дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэлд шинээр улсын дугаар олгохгүй байхаар шийдвэрлэсэнтэй холбоотойгоор оны эхний хагаст суудлын машины импорт нэмэгдсэн. Харин суудлын автомашины цэвэр импорт 3 дугаар улиралд 199 сая ам.доллар байсан нь өмнөх оны мөн үеэс 43 хувиар бага байна. Үүнд нэг талаас нийслэлд хуучин машинд дугаар олгохгүй байх шийдвэр мөрдөгдөж эхэлсэн, нөгөө талаас 2024 оны 3 дугаар улиралд суудлын автомашины импорт 2 дахин нэмэгдэж байсан тул суурийн нөлөө өндөр байв⁷.

72. Төслүүдийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, барилгын материалын импорт өслөө. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар барилгын материалын импорт 1,132 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн байна. Мөн Эрдэнэбүрэн УЦС, Газрын тосны үйлдвэр, Сэлбэ дэд төв, Туулийн хурдны зам зэрэг томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр оны эцэст ч барилгын материалын импортын өсөлт өндөр хадгалагдахаар байна.

73. Худалдааны гол түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарснаар импортын барааны зардал бага түвшинд байв. Импортын үнийн дүнгийн индекс 100 хувь буюу өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар буурсан байна. Худалдааны гол түнш орнуудын үнийн өсөлт саарснаар импортын барааны үнийн өсөлт саарлаа. Тухайлбал, манай улсын нийт импортын 40 хувийг бүрдүүлж буй БНХАУ-ын инфляц 2025

⁷ НИТХ-ын 2024 оны 18 дугаар тогтоолоор Нийслэлд олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дээд хязгаарыг 730,000 байхаар тогтоосон. Үүнтэй холбоотойгоор суудлын


автомашин импорт 2024 оны 3 дугаар улиралд 90 хувиар огцом нэмэгдэж 347 сая ам.долларт хүрч байв. Улмаар 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Улаанбаатар хотод олгох тээврийн хэрэгслийн дугаарын дээд хязгаарт хүрсэн.

оны 3 дугаар улиралд -0.2 хувь байв. Харин нийт импортын 24 хувийг бүрдүүлж буй ОХУ-ын инфляц 2025 оны 3 дугаар улиралд 8.3 хувь байгаа ч тус улсаас импортолж буй бүтээгдэхүүний 21 хувийг АИ-92 автобензин, 47 хувийг дизелийн түлш бүрдүүлж байгаа бөгөөд дээрх нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт бага байна. Тухайлбал ОХУ-ын Роснефть компанитай

2022 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу АИ-92 шатахууныг тогтвортой үнээр худалдан авч байгаа бөгөөд харин ОХУ-ны дизелийн түлшний үнэ буурч байгаа нь импортын барааны үнийн өсөлт бага байхад нөлөөллөө.

Зураг 4.2. Импорт

1.Импортын жилийн өсөлт (нэгж хувь)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2.Импортын үнийн индекс (хувь, өмнөх оны мөн үеэс)



Эх сурвалж: YCX

3.Импортын голлох бүтээгдэхүүн (сая ам.доллар)

Бүтээгдэхүүн	2024.III	2025.III	Жилийн өөрчлөлт
Суудлын автомашин	804	861	7.1%
Хүнс	839	885	5.5%
Барилгын материал	1,028	1,132	10.1%
Тоног төхөөрөмж	1,599	1,719	7.5%
Шатахуун	1,452	1,411	-2.8%
Ачааны машин	566	414	-27.0%
Нийт	8,608	8,534	-0.9%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Шигтгээ 4. Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 51 дугаар тогтоол

2025 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын экспортын орлого 6.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар, нүүрсний экспортын биет хэмжээ 37.9 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар тус тус буурав. Түүнчлэн, уул уурхайн бүтээгдэхүүний бирж дэх нүүрсний арилжаа 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2.4 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 6 дахин буураад байв.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан уул уурхай болон бусад салбарын экспортыг нэмэгдүүлэх, салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны 7 дугаар сарын 21-ын өдөр Ерөнхий сайдын 41 дугаар захирамжаар байгууллаа. Тус ажлын хэсгээс “Экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 51 дугаар тогтоолыг Засгийн газарт танилцуулан 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдөр баталсан.

Тус тогтоолын экспортод үзүүлэх үр нөлөө:


Засгийн газрын 51 дүгээр тогтоолын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан нүүрс тээвэрлэх жолоочтой тээврийн хэрэгслийг Гашуунсухайт боомт дахь Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминалын ухаалаг гарцаар нэвтрүүлж эхлэв.
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах эрчим хүчний нүүрсний үнийг зах зээлийн үнийн индексийн хөдөлгөөнд нийцүүлэн өөрчлөх боломжийг олгох зорилгоор холбогдох журмын өөрчлөлтийг хийв.
- Гаалийн төв лабораторид нүүрсний дээжийг 48 цагийн дотор шинжилж, хариу гардаг тогтолцоог бий болгов.
- ✓ Хилээр нэвтрэх уул уурхайн экспортын бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэл, манифестийг нөхөн бичих, хянах, бүртгэх, дамжуулах үе шатыг бүрэн цахимжуулав. Тээврийн жолоочоос цаасан баримт материалыг шаардахгүй, шалгахгүй болов.

Дээрх арга хэмжээний үр дүнд Монгол Улс 2025 оны эхний хагас жилд 6.6 тэрбум ам.долларын экспорт хийж, сарын дундаж экспорт 1.1 тэрбум ам.доллар байсан бол 7–11 дүгээр сард 7.2 тэрбум ам.долларын бараа, үйлчилгээ экспортолж, сарын дундаж экспорт 1.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх хагас жилтэй харьцуулахад ойролцоогоор 30 хувиар өсөв. Улмаар 2025 оны эхний 11 сарын байдлаар нийт экспортын хэмжээ 13.7 тэрбум ам.долларт хүрч, оны эцэст 15.6 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

- Мөн уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан нүүрсний хэмжээ 2025 оны эхний хагас жилд 2.3 сая тонн болж буурсан байсан бол цогц арга хэмжээг хэрэгжүүлсний дараа 7–11 дүгээр сард 16.9 сая тонн болж, 7 дахин нэмэгдэв. Түүнчлэн биржээр арилжаалагдаж буй нүүрсний үнийн өсөлт 2025 оны эхний 7 сард 3.2 хувь болж саарсан байсан бол 2025 оны 8–11 дүгээр сарын хугацаанд 8.4 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 4.3. Экспортын голлох үзүүлэлтүүд



4.2. Төлбөрийн тэнцэл, гадаад өр

74. Үйлчилгээний болон анхдагч орлогын дансны тэнцэл сайжирч урсгал дансны алдагдал агшлаа. Энэ оны эхний 3 улиралд бараа, үйлчилгээний импорт агшиж, үйлчилгээний болон анхдагч орлогын дансны алдагдал өмнөх оны мөн үеэс буурлаа. Мөн оны эхний хасагт огцом буурч байсан барааны экспорт сайжирч 10.3 тэрбум ам.долларт хүрснээр урсгал дансны алдагдал 1.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8 хувиар буурлаа.

75. Тээврийн болон барилгын үйлчилгээний алдагдал буурсан нь нийт үйлчилгээний дансны тэнцэл сайжрахад голлон нөлөөллөө. Үйлчилгээний дансны алдагдал 2025 оны эхний 3 улирлын байдлаар 2.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 239 сая ам.доллараар буурлаа. Үйлчилгээний дансны алдагдлын 36 хувь буюу 0.7 тэрбум ам.долларыг аялал жуулчлалын үйлчилгээ, 23 хувь буюу 0.5 тэрбум ам.долларыг бизнесийн бусад үйлчилгээ, 20 хувь буюу 0.4 тэрбум ам.долларыг тээврийн үйлчилгээний алдагдал бүрдүүлж байна. Оны эхний 3 улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад ачаа тээврийн үйлчилгээний зардал 67 сая ам.доллараар буурч, нөгөө талаас орлого 156 сая ам.доллараар өссөнөөр тээврийн үйлчилгээний алдагдал өмнөх оны мөн үеэс 223 сая ам.доллараар буюу 35 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа. Мөн өмнөх оны мөн үед 160 сая ам.доллар байсан барилга, угсралтын үйлчилгээний зардал 65 сая ам.долларт хүрч буурсан нь нийт үйлчилгээний дансны алдагдал буурахад эергээр нөлөөллөө.

76. Аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал өмнөх оны мөн үеэс нэмэгдлээ. Нийт аялал жуулчлалын үйлчилгээний дансны алдагдал 741 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар нэмэгдлээ. Үүнд, 2025 оны эхний 3 улирлын байдлаар эмчилгээтэй холбоотой аяллын үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеэс 77 сая ам.доллараар буюу 47 хувиар


буурсан бол боловсролын үйлчилгээний төлбөр 79 сая ам.доллараар, бусад хувийн аяллын зардал 131 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөллөө. Улсын хилээр орсон жуулчдын тоо 2025 оны эхний 3 улиралд 687 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 93 мянгаар буюу 15 хувиар өссөн ба үүнд БНХАУ-ын жуулчид 43 мянгаар, ОХУ-ын жуулчид 9.4 мянгаар, Япон улсын жуулчид 8.3 мянгаар тус тус нэмэгджээ. Харин жуулчлалын зорилгоор гадаадад зорчсон Монгол иргэдийн тоо 2025 оны эхний 3 улиралд 299 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 67 мянгаар буюу 29 хувиар өссөн байна.

77. Бэлэн мөнгө ба харилцах дансны тэнцэл сайжирч, санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс нэмэгдлээ. Санхүүгийн дансны ашиг 2025 оны эхний 3 улирлын байдлаар 2.0 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.9 тэрбум ам.доллараар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд өмнөх оны эхний хагаст төв банк своп хэлцлийн 0.6 тэрбум ам.долларын төлбөрийг гүйцэтгэсэнтэй холбоотойгоор бэлэн мөнгө ба харилцах дансны гарах урсгал өндөр байсан суурийн нөлөө голлон нөлөөллөө.

78. Шууд хөрөнгө оруулалтын орох урсгал буурлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт орох урсгал 2025 оны эхний 3 улиралд 2,350 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 24 хувиар буюу 746 сая ам.доллараар буурлаа. Нийт шууд хөрөнгө оруулалтын бууралтад уул уурхайн салбарын шууд хөрөнгө оруулалт 1,744 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 788 сая ам.доллараар буюу 31 хувиар буурсан нь голлон нөлөөллөө. Мөн мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 43 сая ам.доллараар, худалдааны салбарын шууд хөрөнгө оруулалт 4 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин санхүү болон даатгалын үйл ажиллагааны шууд хөрөнгө оруулалт 87 сая ам.доллараар, удирдлагын

болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хөрөнгө оруулалт 34 сая ам.доллараар тус тус өссөн байна.

Зураг 4.4. Урсгал болон санхүүгийн дансны тэнцэл, төгрөгийн ханш



79. Гадаад валютын нөөц нэмэгдэж төгрөгийн ам.доллартой харьцах ханш чангарлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 3 дугаар улирлын эцэст 5,875 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1,212 сая ам.доллараар, өмнөх улирлаас 668 сая ам.доллараар тус тус өслөө. Ингэснээр энэ оны эхний хагаст 160 төгрөгөөр огцом суларч байсан төгрөгийн ам.доллартой харьцах албан ханш 2025 оны эхний 3 улирлын эцэст 3,593 төгрөгт хүрч тогтворжлоо. Худалдааны түнш орнуудын валютаар жигнэсэн төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 2025 оны эхний 3 улирлын эцэст өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар суларсан бол үнийн өөрчлөлтийн нөлөөг хассан бодит ханшийн индекс өмнөх оны мөн үеэс 5.5 чангарсан байна.

80. Нийт эдийн засгийн хадгаламж буурснаар урсгал дансны алдагдал тэллээ. Урсгал дансны тэнцлийг тухайн улсын нийт хадгаламж болон хөрөнгө оруулалтын зөрүүгээр мөн тайлбарладаг. Сүүлийн 10 жилийг авч үзвэл манай улсын хөрөнгө оруулалтын хэрэгцээ хадгаламжаас давж, 2023 оноос бусад онд урсгал данс алдагдалтай байсан. Сүүлийн 4 улирлын нийлбэрээр тооцсон урсгал дансны алдагдал 2025 оны эхний 3 улирлын эцэст ДНБ-

ий 11.1 хувьтай тэнцэж, өмнөх оны мөн үеэс 9 нэгж хувиар нэмэгдлээ. Үүнд хэрэглээний өсөлтөөс үүдэлтэйгээр хадгаламж өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурч, нөгөө талаас хөрөнгө оруулалт 2.2 нэгж хувиар өссөн нь нөлөөллөө. Нийт эдийн засгийг төр болон хувийн хэвшилд хуваан харвал, Засгийн газар болон хувийн хэвшлийн хадгаламжийн бууралт хөрөнгө оруулалтын өсөлтөөс давсан үзүүлэлттэй байна.

81. Гадаад хөрөнгө оруулалтын позиц сул хэвээр байна. Гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө болон Монгол Улс бусад улсад төлөх үүрэг бүхий өр төлбөрийн зөрүүг харуулдаг гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2025 оны эхний 3 улирлын эцэст -45.7 тэрбум ам.долларт хүрч, ДНБ-ий -190 хувьтай тэнцэж байна. 2025 оны эхний 3 улирлын байдлаар Монгол Улсад байршиж буй гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн 57.5 тэрбум ам.долларт хүрсэн нь гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгөөс 4.8 дахин их байна. Гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 61 хувь буюу 35.1 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, 25 хувь

буюу 14.5 тэрбум ам.доллар нь зээл байна. Харин гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 49 хувь буюу 5.9 тэрбум ам.доллар нь нөөц хөрөнгө байна.

82. Төрийн болон хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл өслөө. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2025 оны 3 дугаар улирлын эцэст 40.4 тэрбум ам.доллар болж, өмнөх улирлын эцсээс 0.8 тэрбум ам.доллараар буюу 2.0 хувиар өслөө. Сектороор харвал, өмнөх улирлаас төв банкны гадаад өр 145 сая ам.доллараар, Засгийн газрын гадаад өр 67 сая ам.доллараар буурсан бол хадгаламжийн байгууллагын гадаад өр 307 сая ам.доллараар, бусад хувийн хэвшлийн гадаад өр 443 сая ам.доллараар тус тус өссөн байна.


83. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдлийн өсөлтийн дийлэнхийг санхүү болон уул уурхайн салбар бүрдүүлээ. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдлийн өсөлтийн 64 хувь буюу 669 сая ам.долларыг санхүү болон даатгалын салбар, 37 хувь буюу 379 сая ам.долларыг уул уурхайн салбар бүрдүүлсэн байна. Бусад салбаруудын хувьд, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, тээвэр, мэдээлэл, холбоо салбаруудын гадаад өрийн үлдэгдэл өмнөх улирлаас өссөн бол боловсруулах, эрчим хүч, үл хөдлөх хөрөнгө зэрэг салбаруудын гадаад өрийн үлдэгдэл буурсан үзүүлэлттэй байна.

84. Улсын нийт гадаад өрийн дийлэнхийг шууд хөрөнгө оруулалт болон зээл бүрдүүлж байна. Улсын нийт гадаад өрийн үлдэгдлийн 45 хувь буюу 18.3 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалттай компанийн өглөг, 36 хувь буюу 14.5 тэрбум ам.доллар нь зээл, 11 хувь буюу 4.5 тэрбум ам.доллар нь бонд байна. Тэр дундаа, зээлийн үлдэгдлийн 45 хувь нь Засгийн газар болон төв банкны зээл, 55 хувь нь хувийн хэвшлийн зээл байна.

85. Гадаад өрийн динамик ханш, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ ханшийн өөрчлөлт, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь төсөөлөлтэй харьцуулахад дунд хугацаанд гадаад өр болон ДНБ-ий харьцаа урсгал дансны үндсэн тэнцэл 1 стандарт хазайлтаар буурахад 10.2 нэгж хувиар, төгрөгийн ханш 10 хувиар сулрахад 18.3 нэгж хувиар тус тус өсөхөөр байна.


Зураг 4.5. Урсгал данс, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өр

1. Урсгал дансны тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

2. Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

3. Гадаад өрийн улирлын өөрчлөлт (сая ам.доллар)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

Тэмдэглэл: ДНБ-д эзлэх хувийг 4 улирлын нийлбэрээр тооцов.


Хүснэгт 4.1. Гадаад өрийн тогтвортой байдал

ГАДААД ӨР												
(өөрөөр тэмдэглээгүй бол ДНБ-д эзлэх хувиар)												
	Гүйцэтгэл							Төсөөлөл				Өр тогтворжуулах урсгал дансны үндсэн тэнцэл
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	
Гадаад өр: Суурь төсөөлөл	217.9	216.1	243.1	221.1	194.4	170.1	156.5	162.4	159.9	160.4	155.3	-10.5
Гадаад өрийн өөрчлөлт	-21.5	-1.7	26.9	-21.9	-26.7	-24.3	-13.6	5.9	-2.5	0.5	-5.1	
Өр үүсгэх урсгалууд	-20.9	-8.4	14.9	-25.2	-11.4	-32.2	-17.6	2.4	-5.5	-3.9	-6.2	
Урсгал дансны алдагдал, хүүгийн төлбөрийг хассанаар	7.7	5.5	-4.9	5.6	4.9	-10.9	-1.3	3.3	1.8	2.8	4.6	
Өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал (-)	-6.9	-7.8	-4.6	-7.6	-0.8	-1.2	-2.0	-1.4	-1.3	-1.2	-1.1	
Өрийн автомат динамик 1/	-21.8	-6.0	24.4	-23.2	-15.6	-20.1	-14.3	0.6	-6.0	-5.5	-9.7	
Нэрлэсэн хүүгийн түвшний нөлөө	9.0	9.7	10.0	8.2	8.5	10.3	10.5	10.0	9.1	8.4	7.0	
Бодит ДНБ-ий өсөлтийн нөлөө	-16.2	-11.3	10.5	-3.5	-9.9	-12.2	-7.4	-8.1	-8.5	-9.2	-9.3	
Үнэ, валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	-14.7	-4.5	3.9	-27.9	-14.2	-18.2	-17.3	-1.3	-6.6	-4.6	-7.5	
Бусад	-0.6	6.6	12.1	3.2	-15.3	7.9	4.0	3.5	2.9	4.4	1.2	
Гадаад өр-экспорт харьцаа (хувь)	374.5	364.8	423.3	377.7	303.4	223.0	228.2	255.1	246.6	257.9	264.7	
Гадаад өр: Гол хувьсагчид түүхэн дундаж түвшинд байх үед 2/								153.6	150.1	148.4	143.4	-6.6
								түүхэн дундаж	стандарт хазайлт			
Бодит ДНБ-ий өсөлт (хувь)	7.7	5.6	-4.6	1.6	5.0	7.4	5.1	3.8	3.7			
Нэрлэсэн гадаад хүү (хувь)	4.3	4.8	4.3	3.9	4.3	6.3	7.2	4.8	1.1			
Экспортын өсөлт (ам.доллараарх, хувь)	12.8	9.7	-9.1	17.1	22.8	41.1	5.3	11.4	16.1			
Импортын өсөлт (ам.доллараарх, хувь)	37.5	3.1	-20.6	26.1	30.9	11.8	21.3	10.6	20.9			
Урсгал дансны тэнцэл, хүүгийн төлбөр хассанаар	-7.7	-5.5	4.9	-5.6	-4.9	10.9	1.3	-0.4	5.7			
Өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал	6.9	7.8	4.6	7.6	0.8	1.2	2.0	3.5	3.9			


1/ДНБ, гадаад өрийн хүү, ханш зэрэг үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс шалтгаалах гадаад өрийн хэлбэлзэл

2/Гол хувьсагчид буюу урсгал дансны үндсэн тэнцэл, өрийн бус хөрөнгийн цэвэр орох урсгал, бодит ДНБ-ий жилийн өөрчлөлт, ДНБ-ий дефлятор, нэрлэсэн гадаад хүүний үзүүлэлтүүд сүүлийн 10 жилийн түүхэн дундажтай тэнцүү байхаар тооцов.


1. Суурь болон түүхэн дундаж хувилбар




2. Хүүгийн шок



3. ДНБ-ий өсөлтийн шок




4. Урсгал дансны үндсэн тэнцлийн шок




5. Хавсарсан шок

(хүү, урсгал данс, ДНБ-ий өсөлт)



6. Ханшийн шок



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Түүхэн дундаж, стандарт хазайлтыг сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр тооцов. Урсгал данс, ДНБ-ий өсөлтийн шокийг 1 стандарт хазайлтаар, хүүгийн шокийг суурь түвшнээс 1 нэгж хувиар өсөхөөр, ханшийн шокийг 10 хувийн сулралтаар 2025-2026 оны хувьд тус тус тооцов.

Бүлэг 5

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

5.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага

5.3. Олон улсад 2025 онд зарлагдсан индексүүд

5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ТОЙМ

Худалдааны дайн, геополитикийн хурцадмал байдал, бодлогын тогтворгүй байдал зэргийн нөлөөгөөр дэлхийн тодорхой бус байдал түүхэн дээд түвшинд хүрлээ. Үүний улмаас хөрөнгө оруулагчид аюулгүй хөрөнгөд хандах хандлага нэмэгдүүлж, алтны эрэлт өсөж үнэ нэмэгдсэн бол, дэлхийн эдийн засгийн идэвхжил буурснаар нүүрсний эрэлт суларч үнэ буурав. Харин тарифын түр завсарлага болон төсвийн дэмжлэгийн бодлогын нөлөөгөөр ОУВС 2025 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг дээшлүүлэв.

5.1. Дэлхийн эдийн засаг

87. Худалдааны дайнтай холбоотойгоор дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдлээ. Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал эрчимтэй өөрчлөгдөж буй энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн өрнөлд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Тухайлбал, Дэлхийн тодорхой бус байдлын индекс (World Uncertainty Index)-ийн үзүүлэлт 2025 оны 3 дугаар улиралд түүхэн дээд түвшинд хүрээд байна (Зураг 5.1).



88. ОУВС дэлхийн эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг нэмэгдүүллээ. Олон Улсын Валютын сан 10 дугаар сард 2025 оны төсөөллөө 3.2 хувь болгон шинэчлээд байна. Энэ нь 2024 оны өсөлт 3.3 хувь ба цар тахлын өмнөх дунджаас (3.7 хувь) бага боловч 2025 оны 7-р сарын төсөөллөөс 0.2 хувиар, 4-р сарын төсөөллөөс 0.4 хувиар өндөр байна. Өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлэхэд АНУ-Хятад тарифыг түр хугацаагаар хойшлуулсан, оны эхний хагаст тариф нэмэгдэхээс өмнөх урьдчилсан худалдан авалт (front-loading) нэмэгдсэн, хөрөнгийн зах зээл сэргэсэн, АНУ, Хятад, Герман зэрэг том эдийн засгуудын төсвийн тэлэлт зэрэг нөлөөлсөн. Хэдийгээр худалдааны дайны эдийн засагт үзүүлэх нөлөө анхны хүлээлтээс (2025 оны 4-р сард ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2026 оны 1-р сарын төсөөллөөс 0.5 хувиар бууруулж 2.8 хувь болгосон) бага

нөлөөтэй байсан ч өмнөх оны мөн үеийн төсөөллөөс 0.2 нэгж хувиар бага байгааг тэмдэглэх нь зүйтэй. ОУВС-аас дэлхийн эдийн засгийн өсөлт 2026 онд 3.1 хувьд хүрч удааширна гэж төсөөлж байна.

89. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 4.8 хувиар өслөө. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт, дотоод эрэлт сул байгаа нь эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж, эдийн засгийн өсөлт тус улсын Засгийн газрын зорилтот түвшин болох 5 хувиас бага гарлаа. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 онд 4.8 хувь, 2026 онд 4.2 хувьд хүрч саарна гэж ОУВС төсөөлж байна.

90. Евро бүсийн эдийн засаг 2025 оны 3 дугаар улиралд 1.4 хувиар өслөө. Бүсийн эдийн засгийн 30 орчим хувийг бүрдүүлдэг ХБНГУ-ын аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна. Худалдааны дайн болон тодорхой бус байдлын нөлөөгөөр эдийн засгийн өсөлт 2025 онд 1.2 хувьд хадгалагдах бол 2026 онд бодит цалингийн өсөлт, ХБНГУ-ын төсвийн тэлэлтийн нөлөөгөөр евро бүсийн эдийн засгийн өсөлт 1.1 хувьд хүрнэ гэж ОУВС тооцоолж байна.

91. Өрхийн хэрэглээ, экспорт болон төсвийн зарлага нэмэгдсэний нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2025 оны 3 дугаар улиралд 2.3 хувиар тэллээ. Худалдааны хурцадмал байдал түр намдаж, АНУ төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлж, санхүүгийн зах зээл сэргэснээс шалтгаалан ОУВС тус улсын эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг 2.0 хувь, 2026 оны өсөлтийн төсөөллийг 2.1 хувь болгож, өмнөх төсөөллөөс тус тус 0.1 нэгж хувиар нэмэгдүүлээд байна. Гэсэн хэдий ч бодлогын тодорхой бус байдал, худалдааны саад, хөдөлмөрийн зах зээлийн өсөлт саарснаар эдийн засгийн өсөлт 2024 оны түвшин (2.8 хувь)-тэй харьцуулахад суларсан үзүүлэлттэй байна.

5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага

92. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн дундаж үнэ 2025 оны эхний 11 сарын байдлаар 9,764 ам.доллар болж, өмнөх оноос 6.8 хувиар өссөн байна. АНУ-ын тарифын бодлогын шийдвэрүүдээс үүдэлтэй томоохон үйлдвэрүүдийн зэсийн нөөцийн хэлбэлзэл дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэд нөлөөлж байна. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж байгаа хэдий ч цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүч, тоон өгөгдөл боловсруулах төвүүд, технологийн салбарын хурдацтай хөгжлөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байна.

93. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2025 оны эхний 11 сарын байдлаар 187 ам.доллар болж, өмнөх оноос 23.2 хувиар буурлаа. Дэлхийн коксжих нүүрсний хэрэглээний хоёрдогч том хэрэглэгч болох Энэтхэг улс руу чиглэсэн гангийн нийлүүлэлт нэмэгдсэн, БНХАУ-ын ган хайлуулах томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний татан авалтаа удаашруулсан зэрэг нь коксжих нүүрсний үнэ буурахад голлон нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас шалтгаалан нүүрсний үнэ буурах дарамт нэмэгдэж байна.

94. Лондоны металлын бирж дэх алтны дундаж үнэ 2025 оны эхний 11 сарын байдлаар 3,362 ам.доллар болж, өмнөх оноос 40.7 хувиар өссөн

байна. АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 2024 онд бууруулсан нь алтны эрэлтийг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал нэмэгдэж байгаатай холбоотойгоор алтны үнэ үргэлжлэн өсөх төлөвтэй байна.

95. Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) үнэ 2025 оны эхний 11 сарын байдлаар 101 ам.доллар болж, өмнөх оноос 7.9 хувиар буурлаа. Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлтийн өсөлт, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт төмрийн хүдрийн үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар богино хугацаанд сэргэх төлөвгүй байгаагаас гадна Австрали, Бразил зэрэг улсуудын олборлолт тогтвортой өсөхөөр байгаа тул төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна.

96. Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 69 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 7.9 хувиар буурлаа. АНУ болон Канад, Бразил зэрэг улсуудын газрын тосны олборлолт нэмэгдсэнээс гадна БНХАУ-ын эрэлт бага байсан нь газрын тосны үнэ буурахад голлон нөлөөллөө. Геополитикийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн удаашралаас шалтгаалан газрын тосны үнэ буурах төлөвтэй.


Зураг 5.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ

1. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн гүйцэтгэл (\$/тонн)



Эх сурвалж: Блүүмберг

2. Зүүн хойд БНХАУ дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын гүйцэтгэл (\$/тонн)




Эх сурвалж: Блүүмберг

3. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний гүйцэтгэл (\$/тонн) 4. Брент газрын тосны гүйцэтгэл (\$/баррель)



Эх сурвалж: Блүүмберг



Эх сурвалж: Блүүтберг

5.3. Олон улсад зарлагдсан индексүүд

97. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс: Фрэйзер институтээс жил бүр тооцоолон гаргадаг Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр Монгол Улс 2025 онд дэлхийн 165 улсаас 75 дугаарт эрэмбэлэгдэж өмнөх оноос 1 байр урагшиллаа. Манай улсын үнэлгээг бүлгээр задалбал дараах байдалтай байна.

Хүснэгт 5.1. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Бүлэг	2024		2025	
	Оноо	Байр	Оноо	Байр
Засгийн газрын хэмжээ	6.54▲	#91▼	6.75▲	#77▲
Хуулийн тогтолцоо ба өмчийн эрх	5.85▲	#58▼	5.77▼	#60▼
Мөнгөний үнэ цэнэ	7.51▲	#90▼	7.78▲	#83▼
Олон улсын худалдааны эрх чөлөө	7.29▲	#80▼	7.28▼	#80▼
Зохицуулалт	6.49▲	#73▲	6.57▲	#71▼
Нэгдсэн индекс	6.74▲	#76▼	6.83▲	#75▲

Манай улсын хувьд 2025 онд Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр 6.83 оноо авсан байна.

Үзүүлэлтээр задлан харвал Засгийн газрын хэмжээ бүлгийн үнэлгээ 0.21 оноогоор буюу 14 байраар, Мөнгөний үнэ цэнэ бүлгийн үнэлгээ 0.27 оноогоор буюу 7 байраар, Зохицуулалт бүлгийн үнэлгээ 0.08 оноогоор буюу 2 байраар тус тус ахисан байна.

Эдгээр үзүүлэлтүүдээр оноо ахисан боловч бусад улс орнуудын үнэлгээ мөн сайжирсан тул манай улсын эрэмбэ төдийлөн сайжраагүй байна. Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийг тооцохдоо 5 бүлгийн 25 дэд бүлэг үзүүлэлтээр бүлэг бүрд ижил жин өгч тооцдог. 25 дэд бүлэг нь мөн цааш шалгуур үзүүлэлтүүдэд задардаг бөгөөд дэд бүлэг бүр харилцан адилгүй шалгуур үзүүлэлтүүдээр хэмжигддэг. Тухайлбал Мөнгөний үнэ цэнэ бүлэг зөвхөн 4 тоон үзүүлэлтээр хэмжигдэх бол Зохицуулалт бүлэг тоон болон чанарын 17 үзүүлэлтээр хэмжигдэж байна. Иймд хамгийн бага шалгуур үзүүлэлт

бүхий дэд бүлэг индексийн үнэлгээнд хамгийн их нөлөө үзүүлж байгаа гэж тооцвол Инфляцын түвшин дангаараа индексийн үнэлгээний 10 хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, инфляцын үзүүлэлтийг сайжруулснаар Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн үнэлгээг хамгийн хялбараар сайжруулах боломжтой гэсэн үг юм. Инфляцын үзүүлэлтийг инфляцын сүүлийн 5 жилийн стандарт хазайлт болон инфляцын жилийн дундаж түвшнээр хэмждэг бөгөөд үзүүлэлт бага гарах тусам сайн, өндөр гарах тусам муу гэж үнэлэгддэг. Гэтэл Монгол Улсын инфляцын жилийн дундаж түвшин 2022 он (Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2024 оны үр дүн нь 2022 оны тоо, мэдээлэлд суурилж тооцогдсон)-д 15.2 хувьд хүрч нэмэгдсэн нь индексийн үнэлгээг бууруулах гол шалтгаан болсон байна. Харин 2023 он (Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2025 оны үр дүн нь 2023 оны тоо, мэдээлэлд суурилж тооцогдсон)-д инфляцын түвшин 10.4 хувь болж өмнөх оноос 4.8 нэгж хувиар буурснаар тус үзүүлэлт сайжрахад нөлөөлсөн байна.

Тус индексээр Хонконг (БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс), Сингапур, Швейцар, Шинэ Зеланд, АНУ, Ирланд, Австрали ба Тайван (7-р байранд тэнцэж), Дани, Нидерланд зэрэг улсууд тэргүүлж байна. Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтээр тэргүүлж буй улс орнуудад төрийн зохицуулалт бага, чөлөөт зах зээлийн тогтолцоо бүрдсэн байна. Тухайлбал, Хонконг (БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс) болон Сингапур нь өрсөлдөх чадвартай эдийн засагтай, бизнесийн чухал төвүүд бөгөөд мөнгөний бодлого тогтвортой, төрийн оролцоо бага байдаг нь бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх таатай орчныг бүрдүүлдэг байна. Чад, Ливи, Сир, Аргентин, Мьянмар, Иран, Алжир, Судан, Зимбабве, Венесуэл улсууд эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтээр жагсаалтын төгсгөлд эрэмбэлэгджээ. Эдгээр улсуудад авлига, хээл

хахууль өндөр, хуулийн хэрэгжилт сул, зохицуулалтын чанар муу, төрийн оролцоо өндөр байна. Үүний зэрэгцээ, тухайн улсуудын эдийн засгийн тогтворгүй байдал, инфляц болон валютын ханшийн хэлбэлзэл нь иргэдийн амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж,

дотоодын эдийн засгийн өсөлтөд саад болдог байна. Мөн эдгээр улсуудад дотоодын болон олон улсын худалдаанд оролцох хязгаарлалт, хамгаалалтын арга хэмжээ их байгаа нь эдийн засгийн эрх чөлөөг бууруулж байна.

Шигтгээ 5. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталсан.

Уг төлөвлөлтийн баримт бичгийг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан судалгаа, шинжилгээнд тулгуурлан, зорилго, зорилт нь хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлт нь зорилгодоо нийцсэн, төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байдлаар бүх талын оролцоог хангаж, нийт 40 төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран боловсруулсан.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөл нь “Шинэ итгэл-Эрс шинэчлэл”-д зорин “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Төрийн бүтээмж, засаглал”, “Бүсийн хөгжил”, “Үндэсний өрсөлдөх чадвар”, “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд Үндэсний, Салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн, Хөтөлбөрийн гэсэн 4 түвшний үр дүнг, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлсон. Дээрх үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулж тодорхойлсон нь олон улсад хүлээсэн манай улсын үүрэг амлалтыг биелүүлэх, нөгөө талаас уг баримт бичгийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чухал алхам юм.

Дээрх бодлогын 8 чиглэлийн хүрээнд үндэсний 10 үр дүнг дараах байдлаар тодорхойлж тусгалаа. Үүнд:

1. Боловсролын чанар болон хүртээмжийн ялгааг арилгаж, эрүүл мэндийн тогтолцооны гүйцэтгэлийн хүрээг тогтоож, хүн-төвтэй, хүртээмжтэй, чанартай, санхүүгийн эрсдэлгүй тусламж, үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэж, дундаж наслалтыг 2 насаар нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцсэн хүний нөөцийг бэлтгэн, хүний хөгжлийн үзүүлэлт 0.756 байгааг 0.85 оноонд хүргэх;
2. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын эзлэх хувь тооцохгүй байгааг тооцож, 2030 онд 20 хувиар нэмэгдүүлэх;
3. Иргэдийн оролцоо, соён гэгээрэл, хамтын хариуцлагыг нэмэгдүүлж, тэгш боломжийг ханган, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн үндэсний соёлын дархлааг бэхжүүлэн, эв нэгдэл, эх оронч үзлийг бататган, үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн үзүүлэлт 2021 онд 49 хувь байгааг 55 хувьд хүргэх;
4. Эрүүл, аюулгүй амьдрах орчин, хүртээмжтэй орон сууц, чанартай нийгмийн хамгааллын үйлчилгээгээр амьдралын чанарыг дээшлүүлж, гэр бүлийн эрүүл тогтвортой байдлыг дэмжиж, хүний эрхийн баталгааг ханган, хүүхдийн хөгжил хамгааллыг шинэ шатанд гаргаж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг тооцохгүй байгааг тооцож, 20 хувиар өсгөж;
5. Боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг дээшлүүлж, бүтээмж, төрөлжилтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн тогтвортой өсөлт 5.1 хувьтай байгааг 6 хувиас дээш түвшинд тогтвортой хадгалах;
6. Анхдагч экосистемийн тэнцвэрийг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, байгалийн нөөц баялгийн нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг дэмжин, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнээс үүсэх бохирдол, хаягдлыг бууруулж, орчны чанар стандартыг сайжруулж байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт 37.2 байгааг 59.0 оноонд хүргэх;
7. Авлигыг бууруулж, иргэдийн шүүхэд итгэх итгэл, шударга ёсны тогтолцоог бэхжүүлж, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлж, батлан хамгаалах, үндэсний сөрөн төсвэрлэх чадавхыг сайжруулж, “Цахимаар түрүүнд” зарчмыг хэрэгжүүлж, иргэн төвтэй үйлчилгээг бүрдүүлж, зөв засаглалын үзүүлэлтээр 114 дүгээр байрт байгааг 90 дүгээр байрт хүргэх;
8. Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгаж, эдийн засгийн хувьд төрөлжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх замаар орон нутгийн хөгжлийн үзүүлэлт 0.506 байгааг 0.604 болгож нэмэгдүүлэх;
9. Бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 61 дүгээр байрт байгааг 50 дугаар байрт хүргэх;

10. Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгааны үр дүн, оюуны өмч, шинэ технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжийг нээж, Дэлхийн мэдлэгийн индекс 47.6 байгааг 52.4 оноонд хүргэхээр төлөвлөсөн.

Хавсралт хүснэгтүүд

Бодит сектор					
	нэгж	2024.I-III	2025.I-III	өөрчлөлт (%)	өөрчлөлт (₮)
Нэрлэсэн ДНБ	тэрбум төгрөг	55,428	60,124	8.5	4,695
Бодит ДНБ	тэрбум төгрөг	22,891	24,250	5.9	1,360
Өрхийн дундаж орлого (нэрлэсэн)	мянган төгрөг	2,509	2,951	17.6	442
		2024.I-III	2025.I-III	өөрчлөлт (%)	өөрчлөлт (мян.хүн)
Ажиллагчдын тоо	мянган хүн	1,347	1,390	3.2	43
Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	62.2	61.9	-0.3	
		2024.I-III	2025.I-III	өөрчлөлт (%)	
Бодит ДНБ-ий өсөлт (үйлдвэрлэл)	хувь	5.2	5.9	0.7	
Уул уурхай	хувь	11.3	8.2	-3.2	
Уул уурхайн бус	хувь	4.4	5.6	1.2	
Хөдөө аж ахуй	хувь	-25.0	33.8	58.8	
Уул уурхай	хувь	11.3	8.2	-3.2	
Боловсруулах	хувь	-2.4	7.7	10.2	
Цахилгаан	хувь	5.2	8.4	3.3	
Барилга	хувь	10.6	22.2	11.6	
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	хувь	12.7	-5.1	-17.8	
Тээвэр	хувь	10.2	-6.1	-16.4	
Мэдээлэл холбоо	хувь	16.1	10.0	-6.1	
Бусад үйлчилгээний салбарууд	хувь	9.7	4.2	-5.5	
Цэвэр татвар	хувь	13.3	-1.8	-15.1	
Бодит ДНБ-ий өсөлт (эцсийн ашиглалт)	хувь	5.6	5.7	0.1	
Эцсийн хэрэглээ	хувь	18.3	6.7	-11.6	
Хувийн	хувь	16.4	9.9	-6.5	
Төрийн	хувь	25.1	-3.7	-28.8	
Хөрөнгийн нийт хуримтлал	хувь	30.8	7.9	-22.9	
Цэвэр экспорт	хувь	-82.2	-10.2	72.0	
		2024.08	2025.08	өөрчлөлт (нэгж %)	
Инфляц (хугацааны эцэст)	хувь	6.1	8.8	2.7	
Хүнсний бараа, ундаа, ус	хувь	7.4	9.9	2.5	
Хүнсний бус	хувь	6.2	8.4	2.2	
Дотоодын	хувь	8.2	12.4	4.2	
Импортын	хувь	3.9	4.9	1.0	

Нэгдсэн төсөв					
		2024.08	2025.08	өөрчлөлт (%)	өөрчлөлт (₮)
Нийт орлого ба тусламж	тэрбум төгрөг	19,880	19,308	-2.9	-572
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	тэрбум төгрөг	18,890	18,072	-4.3	-818
Татварын орлого	тэрбум төгрөг	17,743	16,618	-6.3	-1,125
Орлогын албан татвар	тэрбум төгрөг	5,965	5,245	-12.1	-721
Нийгмийн даатгалын орлого	тэрбум төгрөг	2,865	3,475	21.3	610
Хөрөнгийн албан татвар	тэрбум төгрөг	270	369	36.5	99
Нэмэгдсэн өртгийн албан татвар	тэрбум төгрөг	3,755	3,786	0.8	31
Онцгой албан татвар	тэрбум төгрөг	724	702	-3.0	-22
Тусгай зориулалтын орлого	тэрбум төгрөг	17	17	-1.2	0
Гадаад үйл ажиллагааны орлого	тэрбум төгрөг	1,144	1,213	6.0	69
Бусад татвар, төлбөр, хураамж	тэрбум төгрөг	3,003	1,811	-39.7	-1,191
Татварын бус орлого	тэрбум төгрөг	1,148	1,454	26.7	306
Нийт зарлага ба цэвэр зээл	тэрбум төгрөг	17,318	19,320	11.6	2,001
Урсгал зардал	тэрбум төгрөг	13,683	16,002	16.9	2,319
Хөрөнгийн зардал	тэрбум төгрөг	3,353	3,234	-3.5	-118
Цэвэр зээл	тэрбум төгрөг	283	84	-70.4	-199
Нийт тэнцэл	тэрбум төгрөг	2,562	-12	-100.5	-2,574
Үндсэн тэнцэл	тэрбум төгрөг	3,460	1,173	-66.1	-2,286
Тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	1,572	-1,248	-179.3	-2,820

Гадаад сектор					
	НЭГЖ	2024.08	2025.08	өөрчлөлт (%)	өөрчлөлт (\$)
Экспорт	сая ам.доллар	10,625	9,158	-13.8	-1,467
Импорт	сая ам.доллар	7,502	7,477	-0.3	-25
Худалдааны тэнцэл	сая ам.доллар	3,123	1,681	-46.2	-1,442
Худалдааны эргэлт	сая ам.доллар	18,127	16,635	-8.2	-1,492
<i>Голлох бүтээгдэхүүний экспорт (үнийн дүн)</i>					
Чулуун нүүрс	сая ам.доллар	6,126	3,372	-45.0	-2,754
Хүрэн нүүрс	сая ам.доллар	70	118	69.0	48
Зэсийн баяжмал	сая ам.доллар	1,971	3,444	74.7	1,473
Алт	сая ам.доллар	585	550	-6.0	-35
Газрын тос	сая ам.доллар	223	180	-19.4	-43
Төмрийн хүдэр, баяжмал	сая ам.доллар	399	401	0.5	2
<i>Голлох бүтээгдэхүүний экспорт (биет хэмжээ)</i>					
Чулуун нүүрс	сая тонн	53.7	49.4	-8.1	-4
Хүрэн нүүрс	сая тонн	1.7	3.6	109.3	2
Зэсийн баяжмал	мянган тонн	1,039	1,454	39.9	415
Алт	тонн	8.0	5.4	-31.7	-3
Газрын тос	мянган баррель	2,755	2,386	-13.4	-369
Төмрийн хүдэр, баяжмал	мянган тонн	4,848	5,605	15.6	758
<i>Үнэ</i>					
Чулуун нүүрс*	\$/тонн	114	68	-40.1	-46
Хүрэн нүүрс*	\$/тонн	41	33	-19.2	-8
Зэс	\$/тонн	9,118	9,496	4.1	378
Алт*	\$/унц	2,360	3,250	37.7	890
Газрын тос*	\$/баррель	81	75	-6.9	-6
Төмрийн хүдэр, баяжмал*	\$/тонн	82	71	-13.1	-11
<i>*Хилийн үнэ</i>					
<i>Импорт</i>					
Хэрэглээ	сая ам.доллар	2,612	2,818	7.9	206
Хүнс	сая ам.доллар	735	780	6.2	45
Бензин	сая ам.доллар	415	392	-5.5	-23
Суудлын авто машин	сая ам.доллар	684	806	17.8	122
Аж үйлдвэрлэлийн орц	сая ам.доллар	1,716	1,575	-8.2	-141
Химийн бүтээгдэхүүн	сая ам.доллар	172	173	0.1	0
Дизель түлш	сая ам.доллар	881	850	-3.5	-31
Цахилгаан эрчим хүч	сая ам.доллар	128	139	8.4	11
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	сая ам.доллар	3,166	3,076	-2.8	-89
Машин, механик тоног төхөөрөмж	сая ам.доллар	2,277	2,098	-7.9	-179
Барилгын материал	сая ам.доллар	878	969	10.3	91
Бусад	сая ам.доллар	10	12	28.7	3
2024.08 2025.08 өөрчлөлт (%) өөрчлөлт (\$)					
Гадаад валютын нөөц	сая ам.доллар	4,704	5,683	20.8	979
Төгрөгийн ханш (оны эхнээс дундаж)	MNT/USD	3,385	3,385	0.0	0.0
2024.08 2025.08 өөрчлөлт (%)					
Төлбөрийн тэнцэл	сая ам.доллар	-136	5		141
Урсгал дансны тэнцэл	сая ам.доллар	-1,197	-1,816	51.7	-619
Бараа, үйлчилгээний экспорт	сая ам.доллар	11,098	10,017	-9.7	-1,080
Бараа, үйлчилгээний импорт	сая ам.доллар	10,618	10,399	-2.1	-219
2024.I-II 2025.I-II өөрчлөлт (%) өөрчлөлт (\$)					
ШХО	сая ам.доллар	2,231	1,361	-39.0	-870
Уул уурхай	сая ам.доллар	1,866	1,006	-46.1	-860
Уул уурхайн бус	сая ам.доллар	365	355	-2.8	-10
Мөнгөний үзүүлэлтүүд					
2024.08 2025.08 өөрчлөлт (%) өөрчлөлт (₮)					
Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт	хувь	27.3	6.5		
Зээлийн өсөлт	хувь	33.6	23.6		
Мөнгөний нийлүүлэлт	тэрбум төгрөг	41,565	44,286	6.5	2,721
Нийт зээлийн үлдэгдэл	тэрбум төгрөг	34,224	42,295	23.6	8,071
Чанаргүй зээлийн үлдэгдэл	тэрбум төгрөг	1,970	2,196	11.5	226
Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь	хувь	5.8	5.2		
Зээлийн жигнэсэн дундаж хүү	хувь	17.0	17.0		

Хавсралт

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2023 Q1	2023 Q2	2023Q3	2023Q4	2024 Q1	2024 Q2	2024 Q3	2024 Q4	2025 Q1	2025 Q2	2025 Q3
БОДИТ СЕКТОР											
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	13,971	30,980	47,388	70,442	16,544	37,005	55,428	80,663	17,401	40,262	60,124
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	8.0	6.7	7.2	7.4	8.1	5.7	5.2	5.1	2.6	5.6	5.9
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	7.9	6.3	7.2	7.2	7.9	5.6	4.9	5.1	2.5	5.7	5.9
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	-2.5	-7.1	-1.5	5.4	32.6	27.6	25.4	21.2	8.2	10.4	4.6
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	44.4	37.1	27.7	18.0	-7.5	-1.8	-2.0	0.5	-2.4	-3.0	1.7
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	-34.0	-23.7	-19.0	-16.2	-17.2	-20.3	-18.6	-16.6	-3.2	-1.7	-0.4
Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)											
Эцсийн хэрэглээ	4.1	7.7	9.7	7.0	17.8	16.7	13.2	11.5	9.0	6.9	7.2
Өрхийн хэрэглээ	2.0	4.7	6.3	6.3	12.2	11.7	9.8	8.7	9.7	7.8	7.4
Төрийн байгууллагын хэрэглээ	2.0	3.1	3.3	0.7	5.6	5.0	3.4	2.8	-0.7	-0.9	-0.2
Хөрөнгийн нийт хуримтлал	-6.6	-14.9	-11.2	-1.6	14.8	10.9	12.3	9.7	-0.8	3.5	-2.6
Цэвэр экспорт	10.4	13.4	8.8	1.8	-24.7	-22.0	-20.6	-16.1	-5.6	-4.7	1.3
ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД											
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны дунджаар, хувиар)	12.2	11.6	11	10.4	7.2	6.5	6.4	6.8	9.1	8.4	8.6
Зэсийн үнэ* (\$/тонн)	8,919	8,695	8,582	8,479	8,443	9,094	9,132	9,145	9,330	9,510	9794
Алтны үнэ* (\$/трой. унц)	3,123	2,829	2,695	2,647	2,452	2,641	2,297	2,779	2,840	3,289	3458
ДНБ дефлятор (хувиар)	33.4	24.4	23.1	21.8	9.2	12.5	10.7	8.2	12.5	3.0	2.5
(тэрбум төгрөгөөр)											
НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД											
Нийт орлого ба тусламжийн дүн	5,073	11,059	17,653	24,387	7,673	14,947	22,350	31,375	6,432	14,033	22,244
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	4,795	10,581	16,908	23,295	7,322	14,199	21,290	29,589	6,150	13,215	20,723
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,138	9,034	14,750	22,509	5,695	12,911	19,822	30,365	6,503	13,973	22,058
Нийт тэнцэл	935	2,025	2,903	1,878	1,978	2,036	2,528	1,010	-70	59	186
Нийт үндсэн тэнцэл	1,267	2,539	3,830	3,028	2,380	2,631	3,486	2,205	338	801	1,424
Тэнцвэржүүлсэн тэнцэл	657	1,548	2,158	786	1,627	1,287	1,469	-776	-353	-758	(1,335)
МӨНГӨНИЙ СЕКТОР											
M2 мөнгөний өсөлт (хувиар)	16.8	13.8	20.9	26.8	20.9	31.9	25.9	15.2	10.9	3.7	5.6
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	4.7	2.6	22.6	7.4	11.7	29.6	5.8	51.9	81.3	43.5	19.3
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.9	2.0	2.0	1.9	2.0	1.9	1.9	1.9	2.0	2.0	2.0
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.7	5.4	5.3	5.2	6.1	5.5	6.3	3.9	3.8	4.0	3.1
Зээлийн өсөлт** (хувиар)	8.4	11.5	14.0	22.7	22.3	27.3	31.3	31.0	31.2	25.8	23.6
(сая ам.доллороор)											
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ											
Төлбөрийн тэнцэл	80	474	791	1,457	373	-57	-251	622	-602	-450	53
Урсгал дансны тэнцэл	315	221	430	121	-537	-957	-1,701	-2,485	-959	-1,699	-1,925
ГВУН	3,438	3,818	4,124	4,921	5,250	4,839	4,663	5,510	4,996	5,206	5,875
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	3.2	3.5	3.7	4.4	4.4	3.9	3.5	4	4	4	4
Гадаад валютын ханш											
Валютын ханш USD/MNT (дунджаар)	3,499	3,482	3,475	3,466	3,392	3,386	3,384	3,390	3,454	3,511	3,537
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	3,518	3,433	3,460	3,411	3,376	3,381	3,381	3,420	3,488	3,581	3,593
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	35.5	36.3	37.1	37.6	39.4	39.6	39.5	39.6	39.3	37.0	36.5
Бодит үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	101.9	106.1	109.3	111.1	117.1	118.7	118.9	120.2	126.8	120.7	122.2

*Bloomberg Terminal

**Ипотехийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2023 Q1	2023 Q2	2023 Q3	2023Q4	2024 Q1	2024 Q2	2024 Q3	2024 Q4	2025 Q1	2025 Q2	2025 Q3
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	13,971	30,980	47,388	70,442	16,544	37,005	55,428	80,663	17,401	40,262	60,124
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	5,630	13,661	21,751	30,567	6,084	14,446	22,891	32,133	6,245	15,257	24,250
(өсөлт, хувиар)											
Бодит ДНБ-ий өсөлт	8.0	6.7	7.2	7.4	7.9	5.6	5.0	4.9	2.4	5.6	5.9
Уул уурхайн	48.7	44.9	32.7	23.4	13.3	15.4	11.4	10.8	0.8	1.1	8.2
Уул уурхайн бус	3.2	3.0	4.3	5.4	7.0	4.2	4.0	4.0	2.7	6.3	5.6
Хөдөө аж ахуй	-5.1	-9.9	-9.5	-8.9	-24.8	-26.7	-25.0	-28.7	35.6	35.6	33.8
Уул уурхай	48.7	44.9	32.7	23.4	13.3	15.4	11.4	10.8	0.8	1.1	8.2
Боловсруулах аж үйлдвэр	-6.8	1.6	3.9	5.1	4.9	6.3	0.1	-1.2	3.7	5.8	7.7
Цахилгаан дулаан	4.0	4.7	5.1	5.0	7.7	5.3	5.2	4.8	5.5	8.4	8.4
Барилга	1.2	3.2	4.1	3.1	27.7	19.5	7.8	10.4	-1.1	25.2	22.2
Бөөний болон жижиглэн худалдаа	10.0	7.4	7.0	6.8	6.0	6.8	7.9	6.6	-5.8	-5.7	-5.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	76.6	74.3	58.6	39.6	26.9	24.7	15.7	23.1	-21.6	-12.5	-6.1
Мэдээлэл, холбоо	5.4	11.9	16.9	17.0	27.5	17.4	14.4	15.5	16.5	16.6	10.0
Бусад үйл ажиллагаа	1.6	2.3	3.3	5.8	3.4	7.1	8.6	7.8	7.1	4.5	4.2
Цэвэр татвар	-3.7	2.4	4.1	6.6	13.1	15.0	14.6	16.1	-2.3	0.9	-1.8
Дефлятор	33.4	24.4	23.1	21.8	9.2	12.5	10.7	8.2	12.5	3.0	2.4
(нэгж хувиар)											
ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо											
Хөдөө аж ахуй	-0.2	-1.7	-1.6	-1.3	-1.0	-3.9	-3.5	-3.6	1.0	3.6	3.4
Уул уурхай	5.1	3.9	3.3	2.6	1.9	1.8	1.4	1.4	0.1	0.1	1.1
Боловсруулах аж үйлдвэр	-0.5	0.1	0.3	0.4	0.3	0.4	0.0	-0.1	0.2	0.3	0.5
Цахилгаан дулаан	0.2	0.1	0.1	0.1	0.3	0.2	0.1	0.1	0.2	0.3	0.2
Барилга	0.0	0.0	0.1	0.1	0.2	0.3	0.1	0.3	0.0	0.4	0.4
Бөөний болон жижиглэн худалдаа	1.1	0.8	0.8	0.8	0.7	0.7	0.9	0.7	-0.6	-0.7	-0.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2.2	1.9	2.2	1.8	1.3	1.0	0.9	1.3	-1.2	-0.6	-0.3
Мэдээлэл, холбоо	0.2	0.4	0.5	0.5	0.9	0.6	0.5	0.5	0.6	0.6	0.4
Бусад үйл ажиллагаа	0.6	0.7	1.0	1.7	1.2	2.1	2.4	2.2	2.4	1.4	1.2
Цэвэр татвар	-0.7	0.4	0.6	0.8	2.1	2.3	2.1	2.0	-0.4	0.2	-0.3
(тэрбум төгрөгөөр)											
Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	14,695	30,540	48,503	71,202	16,659	36,790	56,704	80,208	17,911	40,307	61,953
Анхдагч орлого	-2,246	-3,123	-6,455	-8,486	-2,170	-4,697	-8,670	-8,594	-2,431	-4,384	-9,707
Үндэсний нийт орлого	12,449	27,417	42,048	62,716	14,489	32,093	48,034	71,614	15,480	35,923	52,246
Хоёрдогч орлого	477	626	1,177	1,381	570	824	1,406	1,425	489	597	1,117
Үндэсний нийт эзэмшлийн орлого	12,926	28,043	43,225	64,097	15,060	32,917	49,440	73,039	15,969	36,520	53,363
Нийт дотоод эрэлт	12,542	26,812	42,828	64,404	17,005	35,953	56,479	81,027	19,786	42,483	62,100
Үндэсний хадгаламж	5,659	20,826	38,183	59,748	4,833	23,657	43,585	65,930	3,631	25,088	47,429
Хөрөнгийн нийт хуримтлал	3,506	8,062	13,758	23,880	5,179	10,994	18,402	28,672	5,506	12,984	18,077

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2023 Q1 2023 Q2 2023 Q3 2023 Q4 2024 Q1 2024 Q2 2024 Q3 2024 Q4 2025 Q1 2025 Q2 2025 Q3

(тэрбум төгрөгөөр)

НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,073	11,059	17,653	24,387	7,673	14,947	22,350	31,375	6,432	14,033	22,244
Ирээдүйн өв сан	0	0	161	416	284	528	694	841	209	464	973
Тогтворжуулалтын сан	278	478	585	676	67	221	366	444	74	222	294
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,795	10,581	16,908	23,295	7,322	14,199	21,290	29,589	6,150	13,215	20,723
Татварын орлого	4,535	9,841	15,819	21,484	6,909	13,291	19,952	27,377	5,795	12,173	19,024
Орлогын албан татвар	1,431	2,552	4,346	5,703	2,557	4,266	6,402	8,981	2,017	3,742	5,882
Нийгмийн даатгалын орлого	833	1,795	2,744	3,951	920	2,105	3,322	4,700	1,185	2,568	3,967
Хөрөнгийн албан татвар	63	199	292	395	109	240	335	460	141	321	456
Нэмэгдсэн өртгийн албан татвар	982	2,182	3,399	4,777	1,286	2,777	4,313	5,864	1,250	2,884	4,390
Онцгой албан татвар	166	374	593	790	280	515	819	1,098	295	553	767
Тусгай зориулалтын орлого	5	10	16	22	6	13	19	26	7	12	19
Гаалийн албан татвар	314	686	1,063	1,465	352	813	1,315	1,792	394	900	1,392
Бусад татвар,төлбөр, хураамж	741	2,044	3,366	4,382	1,398	2,561	3,426	4,455	506	1,193	2,152
Татварын бус орлого	260	740	1,089	1,811	413	908	1,338	2,212	354	1,042	1,700
Нийтлэг татварын бус орлого	228	620	898	1,452	339	717	1,036	1,770	327	930	1,486
Хөрөнгийн орлого	1	1	4	8	1	2	5	7	1	4	8
Тусламжийн орлого	31	119	188	351	73	188	297	435	26	109	205
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,138	9,034	14,750	22,509	5,695	12,911	19,822	30,365	6,503	13,973	22,058
Урсгал зарлага	3,670	7,557	11,820	17,091	4,698	10,376	15,551	22,067	5,900	12,183	17,821
Цалин, хөлс	457	951	1,547	2,327	1,081	2,585	3,706	5,363	1,511	3,314	4,584
Бараа, үйлчилгээний бусад зардал	482	1,093	1,611	2,758	687	1,660	2,432	4,082	720	1,759	749
Татаас	122	266	382	580	134	367	649	955	243	435	659
Урсгал шилжүүлэг	2,277	4,732	7,353	10,276	2,394	5,170	7,807	10,472	3,017	5,934	8,748
Зээлийн үйлчилгээний төлбөр	333	514	926	1,150	402	595	958	1,195	408	741	1,238
Гадаад	306	460	855	1,054	395	582	943	1,146	407	570	962
Дотоод	26	54	71	96	6	13	15	49	1	171	276
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	468	1,477	2,930	5,418	997	2,535	4,271	8,299	602	1,790	4,237
Хөрөнгийн зардал	488	1,444	2,827	5,188	843	2,296	3,967	7,924	592	1,754	4,122
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-20	33	103	229	154	239	304	374	10	36	115
НИЙТ ТЭНЦЭЛ	935	2,025	2,903	1,878	1,978	2,036	2,528	1,010	-70	59	186
ҮНДСЭН тэнцэл	1,267	2,539	3,830	3,028	2,380	2,631	3,486	2,205	338	801	1,424
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН тэнцэл	657	1,548	2,158	786	1,627	1,287	1,469	-776	-353	-758	-1335
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-657	-1,548	-2,158	-786	-1,627	-1,287	-1,469	776	353	758	1,335
Гадаад	944	111	28	1,041	-67	-72	-197	3,414	76	15	379
ЗГ-ын бонд*	1,009	-262	-262	97	-573	-573	-573	2,623	300	300	438
ЗГ-ын зээл*	-65	374	290	944	506	501	376	791	-224	-285	-58
Дотоод	-1,601	-1,659	-2,186	-1,827	-1,560	-1,216	-1,272	-2,637	277	743	956
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,402	-1,276	-1,687	-1,028	-1,530	-1,123	-1,134	-3,001	277	583	704
ЗГ-ын бонд*	-199	-384	-501	-801	-30	-93	-138	363	0	160	250
ЗГ-ын зээл*	0	0	0	0	0	0	0	0	0	0	0.0
Өмч хувьчлал	0.37	0.59	2.48	2.55	0.04	0.11	0.11	0.84	0.03	0.08	2.30
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

*Цэвэр дүн

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2023Q1 2023Q2 2023Q3 2023Q4 2024Q1 2024Q2 2024Q3 2024Q4 2025Q1 2025Q2 2025Q3

(сая ам.доллараар)

I. УРСГАЛ ДАНС	315	221	430	121	-537	-957	-1,701	-2,485	-959	-1,699	-1,925
Бараа	1,403	2,441	3,498	4,549	945	1,942	2,364	3,081	333	852	1988.6
Экспорт Ф.О.Б (кредит)	3,349	6,738	10,316	13,914	3,431	7,443	11,064	14,750	2,852	6,261	10,316
Импорт Ф.О.Б (дебит)	1,945	4,298	6,817	9,366	2,486	5,501	8,700	11,668	2,520	5,410	-8,327
Үйлчилгээ	-790	-1,374	-1,869	-2,592	-1,044	-1,692	-2,295	-3,317	-876	-1,487	-2,010
Кредит	240	640	1,204	1,587	272	627	1,225	1,604	318	837	1513.91
Дебит	1,030	2,014	3,072	4,179	1,317	2,319	3,520	4,922	1,194	2,324	-3,524
Анхдагч орлого	-434	-1,024	-1,538	-2,233	-606	-1,451	-2,185	-2,671	-556	-1,234	-2,220
Кредит	96	216	330	455	130	272	416	559	142	281	396.59
Дебит	531	1,240	1,868	2,687	735	1,723	2,601	3,230	698	1,516	2,617
Хоёрдогч орлого	136	179	338	398	168	243	416	421	141	172	316.31
II. ХӨРӨНГИЙН ДАНС	22	60	89	135	32	78	120	171	20	51	89.09
Кредит	22	63	95	149	36	87	130	183	21	57	99.92
Дебит	1	3	6	14	4	9	10	12	1	6	10.85
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэгч/зээллэг-)	501	-58	-189	-1,477	-752	-921	-1,107	-3,330	-595	-1,525	-2,187
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-308	-848	-1,393	-2,172	-674	-1,632	-2,047	-2,727	-431	-970	-1823.46
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	-173	101	331	818	-7	-206	-220	-1,105	-76	-129	-663.48
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	0	-1	-1	-2	8	0	-8	-13	8	15	14.03
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	982	690	875	-121	-79	917	1,168	515	-96	-440	285.41
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	474	135	345	354	-229	840	1,095	1,075	-131	55	-907.32
Зээл	80	-133	-117	-529	-89	-48	-187	-630	-133	-187	404.95
Худалдааны зээл	428	688	647	54	239	125	260	70	168	-309	216.98
IV. Алдаа болон орхигдуулга	243	134	84	-276	126	-99	223	-393	-258	-327	-297.89
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	80	474	791	1,457	373	-57	-251	622	-602	-450	53.17
V. Нөөц хөрөнгө	80	474	791	1,457	373	-57	-251	622	-602	-450	53.17
ГВУН	77	456	760	1,398	359	-96	-307	540	-616	-492	8.8
ОУВС-гийн зээл	-2	-17	-32	-59	-14	-38	-56	-82	-14	-42	-44.38
Тусгай санхүүжилт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нэмэлт үзүүлэлтүүд:											
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	3,992	8,898	13,637	20,325	4,877	10,929	16,378	23,793	5,038	11,469	16,999
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	3,438	3,818	4,124	4,921	5,250	4,839	4,663	5,510	4,996	5,206	5,875
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	3.2	3.5	3.7	4.4	4.4	3.9	3.5	4	3.6	4.0	4.5
Валютын ханш MNT/USD (дунджаар)	3,499	3,482	3,475	3,466	3,392	3,386	3,384	3,390	3,454	3,511	3,537
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	3,518	3,433	3,460	3,411	3,376	3,381	3,381	3,420	3,488	3,581	3,593

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2023 Q1	2023 Q2	2023Q3	2023Q4	2024 Q1	2024 Q2	2024 Q3	2024 Q4	2025 Q1	2025 Q2	2025 Q3
	(тэрбум төгрөгөөр)										
Гадаад цэвэр актив	3935	3998	6607	8959	9775	9865	8437	8704	5282	3923	7137
Дотоод цэвэр актив	27004	27450	26604	28665	27625	31603	33366	34630	36202	39076	39940
Дотоодын цэвэр зээл	25335	26874	26600	29106	28477	32296	34091	35343	37667	40652	41880
Бусад цэвэр зүйлс	1669	576	4	-441	-852	-694	-726	-714	-1466	-1576	-1940
M2 мөнгө	30939	31448	33211	37624	37400	41467	41803	43334	41483	42999	43434
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	767	822	838	906	827	1040	961	978	916	937	942
Харилцах болон хадгаламж	30171	30626	32373	36719	36573	40428	40841	42356	40568	40652	42492
	(өсөлт, хувиар)										
Жилийн өсөлт											
M2 мөнгө	16.8	13.8	20.9	26.8	20.9	31.9	25.9	15.2	10.9	3.7	6.2
Гадаад цэвэр актив	222.7	436.9	740.4	259.6	148.4	146.7	27.7	-2.8	-46.0	-60.2	-15.4
Дотоод цэвэр актив	6.9	2.1	-0.3	5.5	2.3	15.1	25.4	20.8	31.0	23.6	11.8
Дотоодын цэвэр зээл	-0.5	0.3	1.6	13.5	12.4	20.2	28.2	21.4	32.3	25.9	22.8
ЗГ-аас авах авлага	171.3	216.7	152.0	91.3	57.9	53.9	30.1	64.2	13.4	36.6	10.4
Бусад салбараас авах авлага	8.7	10.6	12.3	19.8	18.5	24.8	28.5	27.0	28.9	20.6	16.1
Улсын байгууллагаас авах авлага	-5.9	-13.5	-13.4	-16.7	-8.6	13.2	0.2	13.1	4.6	76.3	-0.5
Хувийн сектороос авах авлага	9.5	11.8	13.6	21.7	19.8	25.2	29.6	27.5	29.9	25.5	23.7
	(нэгж хувиар)										
M2 мөнгөний өсөлт дэх оролцоо											
M2 мөнгө	16.8	13.8	20.9	26.8	20.9	31.9	25.9	15.2	10.9	3.7	5.6
Гадаад цэвэр актив	10.3	11.8	21.2	21.8	18.9	18.7	5.5	-0.7	-12.0	-14.3	-3.1
Дотоод цэвэр актив	6.6	2.0	-0.3	5.0	2.0	13.2	20.4	15.9	22.9	18.0	8.7
Нэмэлт үзүүлэлтүүд:											
Мөнгөний эргэлтийн хурд	1.9	2.0	2.0	1.9	2.0	1.9	1.9	1.9	2.0	2.0	2.0
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	44.1	32.7	32.0	30.8	18.4	19.5	17.0	14.5	5.2	8.8	8.5
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	12.2	11.6	11.0	10.4	7.2	6.5	6.4	6.8	9.1	8.2	9.0

